

ЗАВХАН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ /2022 он/

Д/Д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	2022 оны хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
				Он	Түвшин			
НЭГ. ҮНДСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ								
ӨВ СОЁЛ								
1.1								
1.1.1	Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр, үе залуучуудад сурталчлан таниулж, өвлөн уламжлуулна		Хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо	Жилд хоёр удаа	1,500	20,000	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын ажлын хүрээнд Register3-аас Register4 программд шилжиж, улсын хамгаалалтад байх 6, Аймаг нийслэлийн хамгаалалтад байх 21, нийт 27 дурсгал, орон нутгийн хамгаалалтад байх 658 цэгийн 7835 дурсгалын мэдээллийг тус программд оруулсан. "Соёлын биет бус өв"-ийн бүртгэлийн www.ich.mongoluv.mn программд аймгийн 532 өвлөн уламжлагчийн судалгаа, мэдээллийг шинэчлэн баяжилт хийсэн. 2022 оны 06 сарын 22-нд Улиастай сумд "Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадам"-ыг зохион байгуулж, 130 шилдэг өвлөн уламжлагчид гэрчилгээ олгосон. "Нүүдэлчин Монгол" дэлхийн соёлын фестивалд Монгол улсын шилдэг өвлөн уламжлагчаар шалгарсан Д.Даваарагчаа (марзай гийнгоо) Б.Мөнхтуяа (зоосон ширээ сүлжмэл) нарын видео контентыг бүтээж олон нийтэд сурталчлан таниулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 04-ны өдрийн А/530 дугаар захирамжаар улсын тооллого зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, Соёлын биет бус өвийн үзлэг бүсчилсэн судалгааг зохион байгуулах, СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, тархалтыг тогтоож, 24 сумын 532 өвлөн уламжлагчаас 518 өвлөн уламжлагч хамруулаад байна.	50
1.1.2	Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ		Цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Жилд хоёр удаа	0%	4%	Номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн ууган хэвлэл болох Туяа сонин 1946-1990 он хүртэлх дугаарын нийт 9933 нүүрийг Омега программд оруулж сонин хэвлэлийн 87%-ийг цахимжуулаад байна. Мөн уншлага үйлчилгээний зарим нэр төрлийг сайжруулах зорилгоор уншлагын Galaху Tab А7 худалдан авч цахим ном сулгуулах бэлтгэлийг хангаад байна. Номын сангийн интернэтийн хурд удаан цахим ном уншлага явагдах боломж хомс тул "Гайхмаар хурд" ХХК-аас интернэтийн хурдыг 4GB-аар өсгөн авч ашиглаж байна. Мөн гадаад уншлагын хурдыг нэмэгдүүлэх зорилгоор Лингорс байгууллага, Xreading цахим номын сантай хамтран нийт 35 уншигч хүүхдүүдийг гадаад уншлагын марафонд оролцуулаад байна.	70
1.1.3	Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно		Бүтээгдэхүүний тоо	Жилд хоёр удаа	3	24	Түүхэн дурсгалт газруудын мэдээлэл судалгааг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлсэн. "ТӨРСӨН НУТГААРАА АЯЛЦГААЯ" уриатай "УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО- 2022" Үндэсний аялал, жуулчлалын үзэсгэлэн 2022 оны 5 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Мишээл Экспо олон улсын үйлчилгээ, худалдааны төвд амжилттай зохион байгуулагдлаа. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Музей, Аялал жуулчлалын холбоо хамтран аяллын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээ, орон нутгийн онцлог, 9 гайхамшиг, түүх дурсгалын газруудыг сурталчлан ажилласан ба аймгийн музейгээс 16 дэсийн 17 ширхэг үзмэртэйгээр нүүдэлчдийн үзэсгэлэнд оролцсон. Мөн "Завхан нутгийн түүх" 3 боть ном, музейн 100 шилдэг үзмэрийн альбом хийгдсэн байна.	50
1.1.4	Монгол хэл, бичгийн хэрэглээг нийтийн болон албан хэргийн түвшинд нэмэгдүүлнэ		Монгол хэл бичгийг хэрэглэж буй хувь	Жилд хоёр удаа	30%	40%	"Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-3" арга хэмжээг хэрэгжүүлэхэд Орон нутгийн төсвөөс 5,0 сая төгрөгийг тусгаж, "Хос бичигтэн" аяныг 2 сарын хугацаанд зарлаж, ЕБС-ийн 6-12 дугаар ангийн суралцагчид, ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш нар, монгол бичиг сонирхогчид, Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд олон нийтийг хамруулах зорилгоор тодорхой чиглэлүүдийг зааж, мэдээллийг албан байгууллага, аж ахуйн нэгжид албан бичгээр хүргүүлж, үр дүнг "Завхан-Эх хэл бичгээ эрхэмлэе" цахим сүлжээнд байршуулан дүгнэж, шилдэг оролцогчдыг шагнаж урамшууллаа. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд болон боловсролын байгууллагуудын Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын дунд зохион байгуулсан "Хөрвүүлэг"-ийн уралдааны шилдэг өгүүллэгүүдийг эмхэтгэн хэвлүүлэх зардалд 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 23 багшийн 26 өгүүллэгийг эмхэтгэн 200 ширхэг номыг хэвлүүлж, багш суралцагчдад хүргүүлээ. Монгол хэлний тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 дүгээр тушаалаар батлагдсан Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS5283:2022 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж, тайланг ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг чиглэл болгосон. Аймгийн музейн Түүх, Шашин, Угсаатны танхимд дэглэгдсэн үзмэрүүдээс 500 гаруй үзмэрийн хаг тайлбарыг Үндэсний Монгол бичиг-Кирилл Монгол бичиг-Англи хэл бичгээр музейн стандартад нийцүүлэн шинэчлэн сайжрууллаа. Монголын Үндэсний Номын сангийн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан доктор н.Гансүхтэй хамтран 29 дэсийн 38 боть сударт судалгаа хийж, аймгийн музейн 584 судрыг судлан эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан.	50

1.1.5	"Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ		Гүйцэтгэлийн хувь	Жилд нэг удаа	30%	80%	Ардын аман зохиол "Жангар" туулийг хүүхдийн жүжиг, таизны хүртээл болгоход орон нутгийн төсвөөс 13.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн ба Улаанбаатар хот, Улиастай сумд 15 удаагийн тоглолтоор 5000 гаруй үзэгчдэд хүргэсэн байна. "Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадам"-ыг зохион байгуулахад ОНТ-өөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 16 сумын 131 өвлөн уламжлагч оролцож, шалгарсан 43 өвлөн уламжлагч соёлын биет бус өвийн 7 ай савын 58 төрлөөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестивальд оролцож, Монгол улсын шилдэг өвлөн уламжлагчаар 4 шилдэг өвлөн уламжлагч шалгарсан. Хүүхдийн ардын урлаг, соёлын "Яргуй-2022" наадмыг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, тус наадмыг 5 төрлөөр зохион байгуулж, аймгийн ерөнхий боловсролын сургууль, төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх клубын 800 гаруй суралцагчид оролцлоо. Аймгийн соёлын салбарын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөний зардалд 3,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 50 гаруй удирдах ажилтан оролцсон. "Бадархундага" яруу найргийн наадамд орон нутгийн төсвөөс 9,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, наадмын 1-р шатны шалгаруулалтад цахимаар 92 яруу найрагч оролцож, шалгарсан 30 яруу найрагч Улаанбаатар хотод 2-р шатны шалгаруулалтад оролцон шүлгээ уншиж, Завхан аймгийн Шилүүстэй сумын уугуул яруу найрагч А.Бөхням шалгарч, "Болор цом" яруу найргийн наадамд оролцох эрхээ авсан байна. Яруу найргийн наадамтай хамтатган Завхан аймгийн Зохиолчдын чуулга уулзалтыг зохион байгуулж 100 гаруй зохиолчид оролцсон байна.	50
1.1.6	Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна		Хэрэгжилтийн хувь	Жилд хоёр удаа	20%	75%	2022 оны 06 сарын 22-нд Улиастай сумд зохион байгуулсан "Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадам"-д оролцсон 130 шилдэг өвлөн уламжлагчид гэрчилгээ олгож, "Нүүдэлчин Монгол 2022" дэлхийн соёлын фестивальд Монгол улсын шилдэг өвлөн уламжлагчаар шалгарсан Д.Даварагчаа (марзай гийнгоо) Б.Мөнхтуяа (зоосон ширээ сүлжмэл) нарын видео контентийг бүтээж олон нийтэд сурталчлан таниулсан. "Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого"-ыг зохион байгуулахад Соёлын яамнаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан салбар комисс 24 сумын нутаг дэвсгэрт байрлах Улсын хамгаалалтанд байх 6, аймаг нийслэлийн хамгаалалтанд байх 21, орон нутгийн хамгаалалтанд байх 658 цэгийн 7835 дурсгалыг тоолж, RICH4 програмд шивж оруулсан. Монгол Улсын Соёлын яамны зөвшөөрлөөр ШУТИС-ийн Археологийн хамтарсан экспедиц Завхан аймгийн Алдархаан сумын нутаг "Ямаан ус"-нд Хүннүгийн язгууртны дурсгал (булш)-ыг малтан, судалгааны явцад 4 бүлэг 400 гаруй Хүннүгийн үеийн булш, 3 зэргэцээ хэрмийн туурь, 7-р зууны үед холбогдох хадны зураг, Уйгурын шороон бумбагар 2, чулуун зэвсгийн үеийн хадны зураг, Хүрлийн үеийн олон тооны булш зэргийг илрүүлсэн ба малтлага судалгааны ажилд Засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нөмрөг сумын Өвөр шивэртэйн голын буган чулуун хөшөөнд Соёлын өвийн Үндэсний төвтэй хамтран авран хамгаалалт хийхэд Улсын төсвөөс 2.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 04-ны өдрийн А/530 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, "Соёлын биет бус өвийн үзлэг бүсчилсэн судалгааг зохион байгуулах, СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, зэрэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох зорилгоор 24 сумын 532 өвлөн уламжлагчдаас 518 өвлөн уламжлагч хамруулаад байна.	50
1.1.7	Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ		Үйлчилгээний хүртээмж	Жилд 2 удаа	35%	60%	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл II" арга хэмжээ батлагдаагүй байна. Монгол Улсын хүүхэлдэйн театрын уран бүтээл "Өнхрүүш" хүүхэлдэйн жүжгийг аймгийн сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд туурвин хүргэх франчайзингийн гэрээг аймгийн Хөгжимт жүжгийн театрт байгуулсан бөгөөд уран бүтээлчдэд франчайзингийн сургалтыг зохион байгуулж, "Өнхрүүш" жүжгийг Улиастай сумын 9 цэцэрлэгийн 1000 гаруй хүүхдэд хүргэсэн байна. "Жангар" жүжгийг 2022.01.20-нд Монголын үндэсний Олон нийтийн телевизэд бичүүлж Сар шинийн өдрүүд буюу 02 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд цацагдаж, 23000 үзэгчдэд хүрсэн. "УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО- 2022" Үндэсний аялал, жуулчлалын үзэсгэлэнд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Музей, Аялал жуулчлалын холбоо хамтран орон нутгийн аялал жуулчлалын салбараа сурталчлан ажилласан ба аймгийн музейгээс 16 дэсийн 17 ширхэг үзмэртэйгээр нүүдлийн үзэсгэлэнд оролцсон. Соёлын яамнаас 11 дүгээр сарыг "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сар" болгон зарласантай холбогдуулан Үндэсний үнэт зүйл, бүх нийтийн соёлын боловсрол, Соёлын үйлдвэрлэл, Соёлын аялал жуулчлал гэсэн чиглэлээр зохион байгуулж, Цагаан идээ, гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, 1295 хүнд үйлчилж, контент бэлтгэсэн байна. Бүх нийтийн соёлын боловсролын хүрээнд 28 арга хэмжээ зохион байгуулагдаж, 3948 хүн хамрагдаж, "Монгол хүн тэргүүн дээд үнэт зүйл" контент хийгдсэн. Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театр нь Язгуур урлагийн социал контент, "Тэнгэрлэг аялгуу" хөгжмийн дагнасан тоглолт, "Жангар" хүүхдийн жүжиг, "Монгол зүрх бүхэнд" шинэ, шилдэг уран бүтээлийн концерт, "Баавгай лувлах үү" хүүхдийн жүжгийг толилуулсан.	50
1.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							52.86	
НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН							52.86	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
БОЛОВСРОЛ								
2.1								

2.1.1	Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	Хамрагдалтын хувь	Жилд хоёр удаа	30%	95%	2022-2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 38, төрийн бус өмчийн 4 цэцэрлэгийн 191 бүлэгт 5198, үүнээс үндсэн сургалтын 180 бүлэгт 5009, хувилбарт сургалтын 11 бүлэгт 189 хүүхэд хамрагдаж, цэцэрлэгийн хамран сургалт 80.2%, хувилбарт сургалтын хамран сургалт 2.1% болж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 83.3% байна. Ерөнхий боловсролын 29, Монгол Улсын Консерваторын харьяа СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежийн 633 бүлэгт 15790 суралцагч суралцаж, бага боловсролын хамран сургалт 96.5%, суурь боловсролын хамран сургалт 94.6% байна. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургуульд 68 мэргэжлээр 869 оюутан суралцаж байна. (Политехникийн коллежид 582, Консерваторын харьяа СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежид 73, Тосонцэнгэл сумын МСҮТ-д 214), МУИС-ийн Завхан сургуульд 163 оюутан суралцаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд "Смарт кидс" хувийн цэцэрлэгийг шинээр байгуулж, 20 хүүхэд хамрагдаж байна. Ерөнхий боловсролын сургуульд 56 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа бөгөөд насан туршийн боловсролын хүрээнд сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй гэрийн асараанд байдаг 72 хүүхэд гэрийн явуулын сургалтаар боловсролд хамруулж байна. Мөн НҮБ-ын Хүүхдийн сангаас 400 ширхэг радио төхөөрөмжийг сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгож, НҮБ-ын хүүхдийн сангаас дэмжлэгтэйгээр Тосонцэнгэл сумын 1-р сургуульд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд" зориулсан танхимыг шинээр байгуулснаар сургуулийн гадна буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сурч хөгжих боломж бүрдүүлсэн байна. Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрөөр 217 хүүхэд суралцаж байгаагаас шинээр элссэн 11, үүнээс бага боловсролд 9, суурь боловсролд 94, бүрэн дунд боловсролд 114 суралцагч суралцаж байна.	90
2.1.2	Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ	Чанарын үнэлгээ	Жилд хоёр удаа	38%	45%	2021-2022 оны хичээлийн жилд Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулсан сургуульд суурилсан үнэлгээний судлагдахуун бүрийн дунджаар авч үзвэл: Математик 42,5, Физик 35,4, Хими 41,1, Биолог 42,0, Эрүүл мэнд 54,4, Хөгжим 35,7, Англи хэл 27,5, Орос хэл 32,7, Биеийн тамир 60,7, Түүх 34,7, Газар зүй 44,4, Нийгэм 41,5, Монгол хэл 45,8 хувиар үнэлэгдэж, аймгийн суурь болон бүрэн дунд боловсролын дундаж 41.4 хувьтай шалгагдсан бол бага боловсрол 56,7 хувь байна. Ерөнхий боловсролын сургуулийн дунджаар хамгийн бага нь 35,0 хувьтай Нөмрөг, хамгийн их 52,2 хувьтай Цагаанчулуут сумын сургууль, судлагдахууны дунджаар хамгийн өндөр 60,8 хувьтай биеийн тамир, англи хэл хамгийн бага буюу 27,5 хувьтай байна. БҮТ-өөс Чанарын үнэлгээний шалгалтыг Улиастай сумын лаборатори ЧЭЛС, ЖЦС, Тосонцэнгэл сумын 1-р сургуулийн 6,10,12-р ангийн 3 бүлэг тус бүрээс 20 хүүхэд бүрийг сонгож, Политехникийн коллеж, Тосонцэнгэл сумын МСҮТ-ийн 2,3-р курсийн 140 оюутныг сонгож, чанарын үнэлгээний шалгалтад Ерөнхий боловсролын 540, Мэргэжлийн боловсролын 140 хүүхэд хамрагдлаа. Элсэлтийн ерөнхий шалгалтын оноог нэмэгдүүлэх ажлын хэсгийг захирамжаар байгуулж, шалгалтад бэлтгэх, багш суралцагчдыг хөгжүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааны зардалд 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, БШУГ-ын мэргэжилтнүүд 6 бүсэд ажиллаж, 700 гаруй суралцагчдад зөвлөн туслах үйл ажиллагаагаар 1147 цагийн давтлага, сургалтыг зохион байгуулахад 5 ментор багш ажиллаж, 165 багш, удирдах ажилтан хамтран ажилласан байна. Үр дүнд: Элсэлтийн ерөнхий шалгалтад 859 төгсөгч 10 судлагдахуунаар 2413 шалгалтыг өгч, хэмжээст онооны дундаж 509.4 болж өмнөх оноос 14.6-аар нэмэгдсэн байна.	70
2.1.3	Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна	Сургалтын байгууллагын эзлэх хувь	Жилд хоёр удаа	60%	80%	2020-2021 оны хичээлийн жилд Улиастай сумын Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн дотуур байр, Шилүүстэй, Нөмрөг, Цагаанхайрхан, Их-уул, сумын дотуур байруудад шинээр гэрэлтүүлэг хийж, Улиастай сумын 7 дугаар цэцэрлэгт 2.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 9 камер суурилуулан орчин нөхцөлөө сайжруулсан байна. Асгат, Баянтэс, Тэс, Баянхайрхан, Ургамал, Отгон, Яруу, Нөмрөг, Сантмаргаз, Сонгино, Цагаанхайрхан, Түдэвтэй, Дөрвөлжин зэрэг 13 сумын цэцэрлэг, ЕБС-ийн дотуур байрны стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийн 1,2-р ээлжийн 7197,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 объектийг ашиглалтад хүлээн авахаар улсын комисс 2022 оны 10 дугаар сарын 21-24- ний өдрүүдэд ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, ашиглалтад бүрэн хүлээн авсан.	50
2.1.4	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ	Хамрагдалтын хувь	Жилд нэг удаа	60%	85%	Улсын олимпиадын 2-ын давааг 9 судлагдахууны 36 чиглэлээр зохион байгуулж, нийт 30 сургуулийн 6-12 дугаар ангийн 9 судлагдахууны 337 багш, 665 суралцагч оролцсон ба медальт байранд шалгарсан 81 суралцагч, 27 багшийг 2,9 сая төгрөг, СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежийн багш, суралцагчид Оросын холбооны Улсын Улаан-Үүд хотод болсон "НАЙДАЛ- 2022" өсвөрийн хөгжимчдийн уралдаанд оролцоход 5 сая төгрөг, Улсын төрөлжсөн олимпиадын III даваанд 2-р байр эзэлж, мөнгөн медаль авсан 2 суралцагч, Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын XV уралдааны III даваанд 3-р байр эзэлж, хүрэл медаль авсан 1 суралцагч, "НАЙДАЛ- 2022" өсвөрийн хөгжимчдийн уралдаанаас мөнгө, хүрэл медаль хүртсэн 5 суралцагч болон спортын Улсын уралдаанд амжилттай оролцож, эхний 3 байр эзэлсэн 24 суралцагчид 2,8 сая төгрөгийн урамшууллыг олгосон.	50

2.1.5	Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ	Хэрэгжилтийн хувь	Жилд хоёр удаа	30%	80%	СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежийн багш, суралцагчдыг Олон улсын өсвөрийн хөгжимчдийн "НАЙДАЛ-2022" уралдаанд оролцоход 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 4 суралцагч эхний байрт шалгарч, 8 багш мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байна. Улаанбаатар хотоос ирж Жавхлант цогцолбор сургуульд ажилласан англи хэлний ментор багшийн байрны түрээсэнд 1.0 сая, ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэхэд 1.344 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан "Хөдөөгийн багш нарын спортын XIX наадам"-д оролцох багш нарт 3.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 42 хүн оролцож, эрэгтэй шатар 1-р байр, эмэгтэй шатар 4-р байр, эрэгтэй сагсан бөмбөгийн баг 4-р байрыг эзэлсэн байна. Улаанбаатар хотод СУИС-ийн салбар ХБК-ийн "Эгшиглэхүйн Эхлэл" сургууль сурталчлах тайлан тоглолтын зардалд 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 90 багш ажилтан оролцож, ДБЭТ-т нэг удаагийн тоглолтыг 550 хүнд толилуулсан байна. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын сургагч хүүхдийг чадавжуулах сургалтын зардалд 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Монголын багш нарын баярыг угтан аймгийн Засаг даргын нэрэмжит Урлаг спортын анхдугаар наадмыг спортын 7 төрөлд 36 багийн 1254 тамирчин, урлагийн 5 төрөлд 810 багш оролцож, 32.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, "Чадварлаг багш" арга хэмжээнд нийт 64.314 сая төгрөг зарцуулсан байна. Энэ хичээлийн жилд Монгол Улсын Зөвлөх багшийн зэргийн шалгуурыг 8 багш (ЕБС-6, СӨБ-2) хангалаа.	50
2.1.6	Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжин, хамтран ажиллана	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	10%	50%	МУИС-ийн Завхан сургуулийн багш нар 2016-2020 оны аймгийн боловсролын салбарын төсвийн зардалд шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Уг судалгаанд 38 цэцэрлэг, 30 сургууль хамрагдсан бөгөөд зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Ховд аймагт болсон Баруун бүсийн мэргэжлийн сургалтын байгуулагуудын удирдах ажилтан, багш нарын семинарт ХБК, ПТК, Тосонцэнгэл МСҮТ, БШУГ-ын 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй оролцож амжилт ололтоо дүгнэн тулгамдаж буй асуудлуудаа тодорхойлон зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлсэн. Иргэдийн инновацийн санаачлагыг дэмжих МОН-Х хөтөлбөрийн хүрээнд орон нутагт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох судалгаа онлайнаар хийгдэж хог хаягдал их, менежмент муу, үйлдвэрлэл бага, хэрэглээний халуун ус байхгүй гэсэн асуудал иргэдийн дундаас хамгийн тулгамдсан асуудал гэж тодорхойлогдсон байна. МОН-Х хөтөлбөрийн уралдаанд 8 инновацилаг санаа оролцож, Улсын хэмжээний шилдэг 40-д "Завхан ногоон гарц нэгдэл" ТББ-ын "Ногоон гарц эко төв"-ийн инновацилаг санаа шалгарсан байна.	50
2.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН						60.00	
2.2 ЭРҮҮЛ МЭНД							
2.2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын хэрэгжилтийн хувь	Улиралд нэг удаа	70%	80%	Төрийн болон хувийн хэвшлийн 30 эрүүл мэндийн байгууллага Эрүүл мэндийн сайдын 2020 оны 216 тушаалаар батлагдсан нэн шаардлагатай 22 багцын тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2022 онд Артерийн гипертензийн эрт илрүүлэх үзлэгт 17297 иргэн хамрагдаж 36.3%, Чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 14726 иргэн хамрагдаж 50.4 %, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 1667 иргэн хамрагдаж 7.2%, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 483 иргэн хамрагдаж 9.6%-тай байна. Нялхсын эндэгдлийн 23.1 хувийг 0-6 хоногтой нярайн эндэгдэл, 38.5 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл эзэлж байгаа ба нярайн эндэгдлийн түвшин 7.3, перинаталь эндэгдлийн түвшин 5.5 байна. Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн 54.5 хувь нь эрэгтэй, 45.5 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Нялхсын эндэгдлийн 30.8 хувийг гэрийн нас баралтын эзэлж байна. Аймгийн хэмжээнд Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 18 тохиолдол, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 тохиолдлоор буурсан, нялхсын эндэгдэл 13, өмнөх оны мөн үеэс 13 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. 2022 онд нийт 313278 үзлэг хийгдсэн бөгөөд үүний 20.9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 64.4 хувийг өвчний учир амбулаторт, 7.0 хувийг диспансерийн идэвхтэй хяналтын үзлэг, 4.9 хувийг гэрийн эргэлт, 3.7 хувийг гэрийн дуудлагын үзлэг тус тус эзэлж байна. Жирэмсний хяналтад шинээр 1075 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 89.2 хувь нь эхний 3 сартайд хяналтад орсон байна. 2022 оны 5 дугаар сарын 1-ээс хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулж 0-17 насны хүүхдийн үзлэгийг ерх, сумын эрүүл мэндийн байгууллагууд, 18-с дээш насанд хүрэгчдийн үзлэгийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Одчим наран эмнэлэг, Үе залгамжлагч элит сувилал хийж байна. Үзлэгт 0-5 насны 31.5 хувийг, 6-17 насны 58.8 хувийг, 18-30 насны 5.9 хувийг, 31-45 насны 14.4 хувийг, 46-60 насны 18.6 хувийг 61-с дээш насны 19.1 хувийг хамруулаад байна. Нийт хамрагдалт суурин хүн амын 26.1% байна.	70

2.2.2	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	Хамрагдалтын хувь	Жилд хоёр удаа	70%	90%	Нийгмийн эрүүл мэндийн 25 тэмдэглэлт өдрийн хүрээнд: ЭМЯ, НЭМҮТ, СЭМҮТ, НҮБ-с боловсруулан гаргасан сурталчилгааны материал 100 ширхэг зурагт хуудас 26 төрлийн дүрс бичлэгийг байгууллагын цахим хуудас болон 24 сумын Фэйсбүүк группд байршуулан, давхардсан тоогоор 222.299 хандалт хийсэн байна. Аймгийн хэмжээнд дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралт 98.2% ба товллолын насны хүүхдүүдийн дунд вакцинаар сэргийлэгддэг тарилгатай халдварт өвчин бүртгэгдээгүй. 2022 онд нийт 6711 халдварт өвчин бүртгэгдсэнээс Ковид-19-ын тохиолдол 6328 буюу 94.3%, Сүрьеэ 31 / 0.4%/ бусад халдварт өвчин 5.3%-ийг эзлэж байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 сарын 27-ны өдрийн тушаалын дагуу 18-с дээш насны 47311 иргэнээс сүрьеэгийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан 6051 иргэн хамрагдаж хамралт 12.7%-тай, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 5167 хүн хамруулсан байна. Нийт сүрьеэгийн үзлэгээс шинэ 31, давтан 2 тохиолдол бүртгэгдэн эмчлэгдэж байна. Завхан аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой "Уул уурхайн ажилчдын дунд сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, үзлэг шинжилгээ зохион байгуулах гурвалсан гэрээг байгуулснаар Дөрвөлжин сумын Баян айраг эксплорейшн ХХК-ны 261 ажилтанд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулсан. Мөн Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран Сүрьеэтэй өвчний хавьтлын эрт илрүүлэг үзлэг шинжилгээг Алдархаан, Дөрвөлжин, Завханмандал, Ургамал, Эрдэнэхайрхан Отгон,Цэцэн-Уул, Нөмрөг, Тосонцэнгэл, Их-Уул, Улиастай сумдад зохион байгуулж нийт 1314 иргэн хамруулан 4 шинэ тохиолдол илрүүлж эмчилгээнд хамруулсан. Лабораторийн шинжилгээнд нийт 711 иргэн хамруулсан байна. 2022 онд Артерийн гипертензийн эрт илрүүлэх үзлэгт 17297 иргэн хамрагдаж 36.3%, Чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 14726 иргэн хамрагдаж 50.4 %, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 1736 иргэн хамрагдаж 7.2%, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 616 иргэн хамрагдаж 12.3%-тай байна. 2022 онд 1086 эх төрсөн нь өмнөх оноос 236 төрөлт буюу 21.7 хувиар буурсан байна. Гэмтэл хордлого гадны шалтгаант 1376 шинэ тохиолдол бүртгэгдэж, үүнээс 45 тохиолдол нас барсан байна. Танхим болон цахимаар осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 793 төрийн албан хаагч, 182 өсвөр үеийнхэнд зохион байгуулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс "Хүчирхийллийн хохирогч ба үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх 3 өдрийн танхимын сургалтыг 24 сумын эмч нарт зохион байгуулсан.	70
2.2.3	Оношлогоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ	Нэвтрүүлсэн технологи	Жилд нэг удаа	2	5	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлэгт "Ариутгалын тасаг"-ийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулж үйл ажиллагааг явуулснаар хагалгааны чанар, аюулгүй байдал хангагдсан. Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт "Гемодиализийн тасаг"-ийг байгуулж тоног төхөөрөмжөөр ханган эмч сувиллагчийг мэргэшүүлэн үйлчилгээг хүргэж байна. 2022 онд Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд "Эрүүл мэндийг дэмжих төв"-ийг 345 сая төгрөгөөр засвар хийж, суурин ЭХО аппарат 51.5 сая, зөөврийн аппарат 40.2 сая, тирланометр 19.1 сая, аудиометр 19.3 сая, чих хамар хоолойн сандал ком 17.6 сая, ургийн хяналтын монитор 5.0 сая, инкубатор 22.3 сая, сэхээн амьдруулах ширээ 19.3 сая, тариурын автомат шахуурга 1.1 сая, ургийн доплер 540.0 мян, зөөврийн рентген аппарат 65.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Шластины клиникийн III төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу зүрх, тархины мэс засал, мэдрэлийн эмч, ерөнхий мэс заслын эмчийн бүрэлдэхүүнтэй баг 10 дугаар сард 3 хоног ажиллаж доод мөчдийн венийн бүдүүрлийн мэс засал 4, цөсний мэс засал 2, тархины мэс засал 1 хийж мэдрэл, зүрхний эмчийн үзлэгийг 54 иргэнд үзүүлсэн байна. 2022 онд ЭМЯ-наас аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийг 200 сая төгрөгийн үнэ бүхий урологийн доод замын дурангийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж, УНТЭ-ийн хагалгааны баг аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллан бөөр шээсний доод замын дурангийн хагалгааг 9 иргэнд хийж, эмч сувиллагч нарыг ажлын байранд сургаасан.	100
2.2.4	Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	Хамрагдалтын хувь	Хагас жилд нэг удаа	70%	100%	Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд нийт 1145 албан хаагч ажиллаж байгаагаас их эмч 186, сувилагч тусгай мэргэжилтэн 546 ажиллаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч нарын 54 хувь, лавлагаат шатлалын эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмч нарын 95 хувь нь үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшил эзэмшсэн байна. Ахлах зэрэгтэй их эмч 34, сувилагч тусгай мэргэжилтэн 114, Тэргүүлэх зэрэгтэй их эмч 13 сувилагч тусгай мэргэжилтэн 56 байна. Засгийн газрын 2019 оны 05-р тогтоол, 2018 оны 382 дугаар тогтоолуудын дагуу ажлын гүйцэтгэл үр дүн үр чадварыг дүгнэн улирал тутамд урамшууллыг өгч ажилласан. 2022 онд салбарын хэмжээгээр цалин, шагнал, урамшуулалд нийт 14.883 сая төгрөг зарцуулсан нь нийт төсвийн 50.8 хувийг эзэлж байна. Засгийн газрын 2022 оны 107-р тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалтны цалингийн доод жишиг батлагдсантай холбогдуулан Уламжлалт анагаах ухааны төв, Зоонозын өвчин судлалын төв, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийн дарга нарын үндсэн цалинг сар бүр 15 хувиар нэмэгдүүлэн олгохоор шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын 2021 оны 254 дүгээр захирамжаар "Чадварлаг эмч" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж, уг арга хэмжээний хүрээнд "Эмч нарын өдрийг тохиолдуулан 4 эмчийг "Аймгийн Засаг даргын Жуух" мөнгөн шагнал, 12 эмчийг аймгийн Засаг даргын хүндэтгэл мөнгөн шагналаар, олон улсын сувилагчийн өдрийн утган зохион байгуулсан ажил мэргэжлийн уралдаан, Шинэ бүтээл оновчтой санаа эрдэм шинжилгээний хурлын шагналын зардалд 2.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, 5 сувилагчийг "Аймгийн Засаг даргын жуух" мөнгөн шагнал, 15 сувилагчид өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж, 11.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. "Чадварлаг эмч" арга хэмжээний хүрээнд "Чадварлаг баг хамт олон шалгаруулах журам"-ын дагуу 2022 онд 7 Чадварлаг баг хамт олон шалгаруулж нийт 25 сая төгрөгийн урамшууллыг олгосон.	100
2.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН						85	
2.3	БИЕИЙН ТАМИР, СПОРТ						

2.3.1	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ		Үйлчилгээний хүртээмж	Жилд нэг удаа	22%	40%	Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/254 дүгээр захирамжаар "Хөдөлгөөн-Эрүүл мэнд" арга хэмжээг баталж, 4 жилийн ажлын төлөвлөгөөнд 4 зорилт 33 арга хэмжээг хэрэгжүүлж байна. Атка-дансер, Амар –амьдрал ТББ, Индра ТББ-ууд нь бүжиг, иог, дасгал хөдөлгөөний сургалтыг явуулж, аймгийн Засаг даргын нөөц сангаас Атка-дансерд 3.0 сая, Амар –амьдрал ТББ, Индра ТББ-д тус бүр 1.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлснээр бий биелэгээ, шугаман бүжгийг 23 сум, Улиастай сумын 9 цэцэрлэгт хийж хэвшүүлээд байна. Монгол Улсын бүжгийн спортын холбоотой Атка-дансер бүжгийн клуб хамтран зохион байгуулж спорт бүжгийн 67 сургагч багш бэлдсэн. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх ажлын хүрээнд "ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ МОНГОЛ" аяны 7 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 24 сумыг мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. 22 сумын 12697 хүүхэд тогтмол дасгал хийж байна. Үүнээс 8393 хүүхэд хэвшүүлсэн. Өглөөд тогтмол гүйдэг 485, их засварлагааны дасгалыг тогтмол хийдэг ЕБ-ын 18 сургууль байна. Нийт хүн амын 67 хувь нь өдөр тутамдаа эрүүл амьдрах дасгал, хөдөлгөөн, иог, бясалгал, уулын алхалт, өглөөний алхалт, унадаг дугуйн аялал зэрэг спортын аль нэг төрлөөр хичээллэдэг болсон байна	50
2.3.2	Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ		Тамирчдын тоо	Жилд нэг удаа	1830	4500	Аймгийн Засаг даргын 2021 оны 57 захирамжаар үндэсний уламжлалт спорт тоглоом шагайн харвааны "Даян мэргэн" арга хэмжээг батлуулан хэрэгжүүлж байна. "Монгол Шагайн харвааны клуб"-ыг шат дараатай байгуулж байгаа бөгөөд эхний ээлжинд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгээр Улиастай сумын ЕБ-ын 5 сургууль, Политехник коллеж, Алдархаан сумын ЕБС-д байгуулж байна. Аймгийн Засаг даргын нэрэмжит, шилжин явах цомын төлөөх шагайн харвааны нээлттэй тэмцээнийг 2022 оны 3 дугаар сард амжилттай зохион байгуулж, тэмцээнд 17 багийн 140 орчим Шагайчид цэц мэргэнээ сорин наадсан. Үндэсний спортын наадам, Монголын бүх ард түмний спортын наадмын "Аймгийн аварга" шалгаруулах тэмцээнийг 24 төрлөөр зохион байгуулж давхардсан тоогоор 24 сумын 3000 гаруй тамирчид оролцсон. Үндэсний спортын наадмын шигшээ тэмцээнд шалгарсан 200 орчим тамирчдын мэдээллийг цахим мэдээллийн санд шивж "Улсын аварга" шалгаруулах тэмцээнд спортын 14 төрлөөр Монголын бүх ард түмний XV их наадамд 15 төрлөөр 145 тамирчин оролцсон байна. Тамирчдыг оролцуулахад биеийн тамир, спортын зардлаас 21.0 сая төгрөгийг зарцуулж алтан медаль-1, мөнгөн медаль-3, хүрэл медаль-4 нийт 8 медаль авч, 20 тамирчин спортын цол зэргийн болзол хангасан байна. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Нэгдсэн улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээн-2022" тэмцээний багийн тамирчдад 3.0 сая, "Цасны баяр"-ын үйл ажиллагаанд 2.0, "Завхан хийморь эрчүүд" НҮТББ-т 2.0 сая, Даян мэргэн" арга хэмжээний хүрээнд аймгийн тэмцээнд 4.0, "Хөдөлгөөн –эрүүл мэнд" арга хэмжээний хүрээнд ТББ-уудад 5.0 сая, Орхон аймагт зохион байгуулагдсан 21 аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд багт 2.0 сая, Жудо бөхийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчинд 0.5 сая, Бүх ард түмний XV наадмын сагсан бөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээний шагналд 2.8 сая, үйл ажиллагаанд 1.5 сая, Бүх ард түмний XV наадмын Баян-Өлгий аймагт зохион байгуулсан волейболын бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон баг тамирчдад 2.0 сая Монгол улсын Улсын заан, харцага цолны урамшуулал , дэлхийн болон ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдад нийтдээ 50.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.	50
2.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							50	
2.4. ГЭР БҮЛ								
2.4.1	Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна		Хамрагдсан тоо	Жилд нэг удаа	4,993	6,000	Аймгийн Засаг даргын 2021 оны А/492 дугаар захирамжаар гэр бүлд чиглэсэн "Тогтвортой амьдрал, амгалан гэр бүл" арга хэмжээг баталж, 4 зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг төлөвлөн, улсын төсөв, төсөл хөтөлбөр, байгууллагын өөрийн хөрөнгө зэргээс 258.1 сая төгрөгийн санхүүжилттэй 250 үйл ажиллагаа зохион байгуулж, хэрэгжилт 98.13 хувьтай дүгнэгдэж, 2020 онд 6108 гэр бүл, 2021 онд 18677 гэр бүл, 2022 онд 11036 гэр бүл хамрагдсан байна.	100
2.4.2	Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ		Нийт төсвийн зарцуулсан хөрөнгийн хувь	Жилд нэг удаа	0%	10%	Хүүхэд хамгааллын явуулын үйчилгээг зүүн бүс, говийн бүсийн 8 суманд зохион байгуулж, ЕБС 3624 хүүхэд, СӨБ 396 хүүхэд, 1116 эцэг эх, 14 хамтарсан багийн 96 гишүүн, сургууль цэцэрлэгийн 375 багш ажилчдад хүрч ажилласан байна. "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн нэгдсэн зөвлөгөөн" зохион байгуулж, хамтарсан багийн ахлагч, нарийн бичиг, сургуулийн нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан, цагдаагийн ажилтан, хүүхдийн элч нийт 145 албан хаагчийг чадавжуулсан. 2022-2023 оны хичээлийн жилд НҮБХС-ийн дэмжлэгтэйгээр "Миний гэр бүл", "Миний ертөнц" амьдрах ухааны хүүхэд хөгжлийн шаталсан хөтөлбөрт 10080 хүүхэд хамрагдсан. Хүүхдийн оролцооны байгууллагуудыг дэмжиж, ХОБ-ын 70 багшийн үйл ажиллагааг дэмжин, 1000 гаруй хүүхдэд нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. "ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРОН НУТАГ" дэд хөтөлбөрийн үр дүн, сайн туршлагын талаар хүүхдээ сонсох, тэдний үзэл бодлыг хүндэтгэх замаар бодлого төлөвлөх хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд аймгийн хүүхдийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг 10-12 ангийн 1390 хүүхдийг оролцуулан зохион байгуулсан. МИДАС НҮТББ-ын тэргүүн С.Энхжаргал /Магистр/, МУБИС-ийн Нийгмийн ажлын арга зүйн тэнхимийн эрхлэгч Т.Цэндсүрэн /Ph.D/ багшаар удирдуулан судалгааны арга зүйн сургалтад нийт 24 сумын 32 сургуулийн нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын 5 мэргэжилтэн хамрагдаж, судлаачаар бэлтгэгдэж гэрчилгээ авсан.	100

2.4.3	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулна		Хүний тоо	Жилд нэг удаа	21	96	2022 оны жилийн эцсийн байдлаар гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эрсдэлт нөхцөлд байгаа нийт 62 иргэнийг (насанд хүрсэн эмэгтэй 22, хүүхэд 40) хүлээн авч хамгаалах байранд 1-25 хүртэл хоногийн хугацаатай нийт 570 хоног хамгаалах түр байранд байрлуулан, хохирогчдод шаардлагатай цогц үйлчилгээнүүдийг мэргэжлийн багаар үзүүлж ажилласан. НЦҮТ-ийн хашааны дотор талын зургийг сэргээн будаж, тоглоомын талбай, хүлэмж, ногооны талбайтай болж, зам талбайг засварлан хаалганы орох хэсэгт тэргэнцэртэй хүний налуу замтай болгож орчин нөхцөлийг сайжруулах тохижилтын ажил хийсэн. Мөн зөвлөгөө өгөх өрөөнд урлагаар дамжуулан сэтгэл зүйн зөвлөгөө заслын үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлж, номын сантай болсон. Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 2022 оны 04 дүгээр сараас мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтны цалин хөлсийг шийдвэрлэж, ГБХЗХГ-ын дансаар дамжуулж олгож байна. Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусган Засаг даргын захирамжаар 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. ГБХЗХГ-аас нэг цэгийн үйлчилгээнд хамрагдсан кейс шийдвэрлэлтэд нийт 11.5 сая төгрөг шийдвэрлэсэн байна. .	100
2.4.4	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулна		Үйлчилгээний чанарын хувь	Жилд нэг удаа	25%	99%	2022 онд хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 62 дуудлага мэдээлэл ирж, шийдвэрлэн хариу мэдээлэл өгсөн байна. Нийт дуудлагын 30-ыг хамтарсан багийн хяналтанд шилжүүлэн кейс файл нээн ажиллаж байна. 32 дуудлага мэдээллийг шалган шаардлагатай үйлчилгээг үзүүлэн хаасан. Хүүхдийн тусламжийн утасны кейс шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Хүүхэд эцэг эх, асран хамгаалагч, иргэдээс хүлээж авсан 13 өргөдөл гомдлыг хүлээн авч 100% шийдвэрлэсэн байна. Аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог аймгийн ЗД-ын 2022 оны 73 тоот захирамжаар шинэчлэн, журмын дагуу байгуулсан. Баруун бүсэд зохион байгуулагдсан чадавхжуулах сургалтад 92.3%-ийн оролцоотойгоор хамрагдаж, үйл ажиллагаагаа явуулж байна. ХЭХЗХ-ны хуралдааныг танхимаар 3, цахимаар 1, өргөтгөсөн хуралдаан 1 зохион байгуулсан. 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөөг баталж, аймаг орон нутгийн удирдлагын зүгээс 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. ХЭХЗХ-оор 12 хүүхэд үйлчилгээ үзүүлсэн. Хүмүүжлийн албадлагын арга хэмжээ авагдсан нэг хүүхэд сургалтад хамрагдаж байна. Аймгийн өмгөөлөгчдийн холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлсэн 4 өмгөөлөгчид 2.880 сая төгрөгийн урамшуулал олгосон.	100
2.4.5	Хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах түвшинг нэмэгдүүлнэ		Хүний тоо	Жилд нэг удаа	109	172	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 79 иргэнийг хамруулан 148.3 сая төгрөгийг зарцуулаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 79 шинэ ажлын байр бий болгож 9 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад хамруулан гар урлал эрхлэх чадварт сургаад байна. Мөн хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр заалтын хүрээнд 13 иргэнийг байнгын ажлын байраар хангасан.	50
2.4.6	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ		Зөвлөхийн тоо	Жилд нэг удаа	202	300	2022 онд Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 57 ахмад мэргэжилтэн хамрагдсан байна. Үүнээс ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 33 ахмад мэргэжилтэн хамрагдсан. 2022 оны ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг ЕБС төгсөгчдийн ЭЕШ-ын оноог нэмэгдүүлэхэд чиглүүлэн 12 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд ахмад мэргэжилтнүүд зөвлөн тусалж ажиллалаа. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлсэн ахмадын тоо 40. Хүүхэд хамгаалагч үйлчилгээ үзүүлсэн ахмадын тоо 4. Санхүүгийн дэмжлэг авсан ахмадын тоо 36. Зарцуулсан хөрөнгө 100.0 сая төгрөг байна.	100
2.4.7	Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ		Залуучуудын тоо	Жилд нэг удаа	109	172	Залуучуудын хөгжлийн жишиг төвийн үйл ажиллагааг дэмжиж 19.7 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж, 8.8 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж авсан. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн дагуу 7 төрлийн үйлчилгээг тогтмол үзүүлж байна. "Хүчирхэг охид" аппликейшн танилцуулах, сурталчлах сургалт, хэлэлцүүлгийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэмжлэгтэйгээр Улиастай сумын ЕБС-ийн таван сургууль, мэргэжлийн хоёр сургуулийн охидод зохион байгуулж, 160 сурагч хамрагдсан. Уулзалт хэлэлцүүлэгт нийт 773.0 мянган төгрөг зарцуулагдсан. Их-Уул сумын хуучин Соёлын төвийн барилгын аймгийн ОНТ 160 сая төгрөгийн санхүүжилтээр засварлан сумын Залуучуудын хөгжлийн төв үйл ажиллагаагаа явуулж байна.	100

2.4.8	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлнэ		Хамрагдсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	202	300	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцсон "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" хэлэлцүүлэг зохион байгуулан, хэлэлцүүлгээс гарсан саналыг Улаанбаатар хотод болсон үндэсний чуулганд хүргүүлж, чуулганаас гарсан зөвлөмжийг орон нутагт түгээн ажиллаж байна. Жөндөрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Гэр бүлд суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх "Харилцан хүндэтгэе" аяныг 3-р сард, "Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо" аяныг 11-12-р сард өрнүүлэн төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийт идэвхтэй оролцон, хамтран ажиллалаа. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Жөндөр ба хүний эрх" сургалтыг 2022 оны 06 сарын 06-нд аймаг сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт, 06 сарын 07-нд төрийн тусгай, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын дарга нарт зохион байгуулж 250 гаруй төрийн албан хаагчдыг чадавхжуулсан. Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл боловсролтой эр хүн жаргалтай гэр бүлийн үндэс" аймгийн эрэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулан, 17 сумын 230 гаруй төлөөлөгч оролцон, эрэгтэйчүүдийн тулгамдсан асуудлуудаар илтгэл сонсож, санал солилцон, зөвлөмж гарган, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/468 дугаар захирамжаар "Эрчүүдийн зөвлөл" байгуулагдсан. Мөн Гэр бүлийн хүчирхийллэлд өртөгсдөд эрх зүйн тусалцаа үзүүлэх НЦТ-өөр эрсдэлт нөхцөлд байгаа 62 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	100
2.4.9	Халамж зайлшгүй хүрэх зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ		Үйлчилгээ авсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	16176	15124	Сум тус бүр 3-5 өрхийг "Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх хүнсний талонгүй сум болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 447 өрхийн 1125 том хүн, 1013 хүүхэд хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагдаж байна. Халамжаас хөтөлбөрт зорилтын хүрээнд 100 болон түүнээс дээш малтай өрхүүдэд хяналт хийж 206 өрхийн үйлчилгээг зогсоож, 10 сум хүнсний талонгүй сум болоод байна. 2022 онд нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн 16825 иргэнд хүргэж ажилласан байна.	50
2.4 ЗОРИЛТЫН ДҮН								88.89
ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮН								70.97
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА								
3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ								
3.1.1	Ажил эрхэлдэггүй, мэргэжлийн сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна		Залуучуудын эзлэх хувь	Жилд нэг удаа	25.7%	15%	Хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 18-34 насны залуусыг ажил хөдөлмөрт уриалж, урамшуулж, сургаж, дадлагажуулж, ажлын байранд зуучлах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "ОРОЛЦОО" төсөлд 35 залуучуудыг хамруулснаас 13 залуу ажлын байранд зуучлагдсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн шилдэг "СТАРТ-АП" шалгаруулах арга хэмжээнд нийт Завхан аймгийн 32 залуу бүртгүүлсэн. Бүртгүүлсэн залуус 14 баг болж 72 цагийн сургалтад хамрагдаж шилдэг 5 баг шалгарч АРГА ХЭМЖЭЭНИЙ 5 ДОЛОО ХОНОГИЙН ХҮРДАСГУУР ХӨТӨЛБӨРТ хамруулсан. Эцсийн сонгон шалгаруулалтад "Happy house" төсөл шалгарч санхүүгийн дэмжлэгт хамрагдсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс 150 гаруй залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллалаа.	30
3.1.2	Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ		Ажиллах хүчний оролцооны түвшин	Улирал бүр	80%	88%	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд нийгмийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 174 иргэн, хорих ангиас суллагдсан 1 иргэн, зургаан сараас дээш хугацаагаар ажил хайж буй 17 иргэн, нийт 192 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулж, тус иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийж хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд байнгын ажлын байранд 697, улирлын ажлын байранд 53, түр ажлын байранд 554, нийт 1304 иргэн ажилд орсон бөгөөд 666 буюу 51.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн ажлын байрны 774 захиалга ирж, 601 иргэнийг ажлын байранд зуучилсан.	30
3.1.3	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ		Шимтгэл төлсөн иргэдийн хувь	Улирал бүр	23%	60%	Жилийн эцсийн байдлаар 15870 иргэн нийгмийн даатгалд хамрагдсан бөгөөд эдийн засгийн идэвхтэй хүн амын 47.2 хувийг эзэлж байна. Шинээр нийгмийн даатгалд 1121 даатгуулагчийг хамруулснаар нийгмийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо 6 хувиар өссөн байна.	50

3.1.4	Боловсон хүчнийг ажлын байрны захиалгад нийцүүлэн сургаж ажилгүйдлийн түвшинг бууруулна		Ажилгүйдлийн түвшин	Улирал бүр	6.2%	5.9%	Ажилгүй болон ажил хайгч иргэний хөдөлмөр эрхлэлтийн чадварыг үнэлэх, төлөвлөгөө гаргах (Профайлинг) аргачлалыг нэвтрүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээнд хамрагдаж буй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 1100 иргэнийг профайлингийн үйлчилгээнд хамруулсан. Тус үйлчилгээний хүрээнд ажлын байрны захиалгад нийцүүлэн ажил хайгчдыг бэлтгэсэнээр нийт иргэдийн 90 орчим хувь нь байнгын буюу тур ажлын байраар хангагдсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтуудыг оёдол, тогооч, гар урлал, цахим ур чадвар олгох чиглэлээр зохион байгуулж 83 иргэнийг хамрууллаа. Ажилгүйдлийн түвшин 6.3 хувь байна.	30
3.1.5	Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлнэ		Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин	Жилд нэг удаа	74.4%	93.0%	"Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан 7 хөтөлбөр 28 арга хэмжээг нэгдсэн удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн ХЭДЗөвлөлийн 2022.04.26-ны хурлаар 2022-2023 онд сумдад хэрэгжих хөтөлбөрийн хуваарийг баталсан. 24 сумын иргэдэд хуваарийн дагуу хэрэгжих төсөл, хөтөлбөрийг танилцуулах ажлын хэсэг 4 чиглэлд ажиллаж мэдээлэл хүргэсэн. Аж ахуй эрхлэгчдийг дэмжих, ХБИ, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар хүсэлт гаргаж төсөл ирүүлсэн иргэдэд профайлинг буюу хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээнд хамруулах ажлыг хийсэн. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 2022 онд аймгийн хэмжээнд нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаадлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 192 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтанд хамруулж 4.2 сая төгрөгийг зарцуулсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар хүм амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 61 хувь, үүнээс 30-50 насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 73.9 хувь байна."	30
3.1.6	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг цахимжуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ		Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлж, ажилд зуучилсан тоо	Жилд нэг удаа	350	1,500	Аймгийн хэмжээнд ХАА-н салбарт 16087 иргэн, ХАА-н бус салбарт 3690 иргэн албан бус хөдөлмөр эрхэлж байна.	0
3.1.7	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо		Ажлын байрны тоо	Улирал бүр	1250	4500	2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд байнгын ажлын байранд 697, улирлын ажлын байранд 53, түр ажлын байранд 554, нийт 1304 иргэн ажилд орсон бөгөөд 666 буюу 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн 774 ажлын байрны захиалга ирж, 601 иргэнийг ажлын байранд зуучилсан бөгөөд 342 нь эмэгтэйчүүд байна.	50
3.1.8	Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийг багасгана		Ядуурлын түвшингээс доогуур орлоготой хүн амын хувь	Жилд нэг удаа	25.7%	18%	Сум тус бүр 3-5 өрхийг "Халамжаас хөдөлмөрт шилжүүлэх хүнсний талонгүй сум болгох зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 447 өрхийн 1125 том хүн, 1013 хүүхдэд хүнсний эрхийн үйлчилгээнд хамрагдаж байна. Халамжаас хөтөлбөрт зорилтын хүрээнд 100 болон түүнээс дээш малтай өрхүүдэд хяналт хийж 206 өрхийн үйлчилгээг зогсоож, 10 сум хүнсний талонгүй сум болоод байна.	30
3.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								31.25
3.2. БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ								
3.2.1	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж дэмжлэг үзүүлнэ		Санхүүгийн сургалтад хамрагдаж ЖДҮ, ХЭДС-ийн зээл авсан өрхийн хувь	Жилд нэг удаа	10%	100%	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, арилжааны банкуудтай хамтран 23 сумын болон Улиастай сумын 6 багийн 3000 гаруй өрхөд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. Дэлхийн хуримтлалын өдөр-2022 аяны хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хуримтлалыг хэвшил болгоход чиглэсэн үйл ажиллагаануудыг Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумдад зохион байгуулж, аяны хүрээнд гар зураг, зохион бичлэгийн уралдааныг зохион явууллаа. Хоршоог хөгжүүлэх сангаас малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, зах зээлд худалдан борлуулах чиглэлээр төсөл ирүүлсэн Шилүүстэй сумын "Өсөх ундарга булаг" ХХК-нд 20.0 сая, Түдэвтэй сумын "Нүхэн хад салхит" ХХК-нд 15.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Мөн Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийг орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулж баталж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 9 сумын 12 хоршоо, 20 ХХК-нд 893 сая төгрөгийн зээл олгосон байна.	50
3.2.2	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ		Нийлүүлэлтийн гинжин харилцаа тогтоосон бизнес, үйлдвэрийн тоо	Жилд 1 удаа	0	5	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулдаг Завханд үйлдвэрлэв онлайн дэлгүүр болон Хүннү зоогийн газрын танхимд 13 аж ахуйн нэгж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. "Номин Холдинг" ХХК-ийн 21 аймаг 21 брэнд бүтээгдэхүүн арга хэмжээнд "Мөнхөд Мандаг" ХХК гэрээ байгуулан Номин сүлжээ дэлгүүрт 6-7 төрлийн бүтээгдэхүүнийг борлуулах эрхтэй болсон.	30

3.2.3	Сумдын гарааны бизнес эхлүүлж буй иргэдийн ЖДҮХС, СХС, ХЭДС-ийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ		Анх удаа тухайн сангаас зээл авсан зээлдэгч	Улирал бүр	10%	30%	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу ЖДҮХСангийн зээлд хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч шийдвэрлэсэн. 2019, 2020 онд ЖДҮХС-ийн зээл олгосон. 2021 онд ЖДҮХСангийн эх үүсвэр батлагдаагүй тул зээл олгогдоогүй. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор СХСангаас энэ онд 178 иргэнд 1086.2 сая төгрөгийн зээлийг олгосон. Аймгийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар гарааны бизнес эрхэлж байгаа 1269 аж ахуйн нэгж байна. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд Хас банк Улиастай сумын 2 тариаланчдад 30.0 сая төгрөгийн, ХААН банк 19 иргэн, аж ахуйн нэгжид 470.2 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.	30
3.2.4	Малчид, тариаланчид, сумын төвийн өрхийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ		Зохион байгуулалтад орж дундын хуримтлалын сантай болсон бүлэг, хоршоо	Улирал бүр	1350	2500	Хоршоог хөгжүүлэх сангаас 2022 онд 9 сумын 12 хоршоо, 20 аж ахуйн нэгжид 893 сая төгрөгийн зээлийг олгосон. Хоршооны зөвлөгөөн дотоодын туршлага судлах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 29-30-ны өдөр Хэнтий аймгийн Баян-ово суманд зохион байгуулж Дөрвөлжин сумын Завхан буурал хоршоо, Улиастай сумын Цэнхэр хулан хоршоо, Аймгийн ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн хамрагдсан. Хоршооны үнэлгээг журмын дагуу зохион байгуулахаар төлөвлөж байна.	30
3.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								35
3.3.	ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ							
3.3.1	Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээг үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна		Шинээр ашиглалтад орсон спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо	Жилд нэг удаа	43	70	Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Нэгдсэн улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээн 2022" тэмцээний багийн тамирчдад 3.0 сая, "Цасны баяр"-ын үйл ажиллагаанд 2.0, "Завхан хийморь эрчүүд" НҮТББ-т 2.0 сая, "Даян мэргэн" арга хэмжээний хүрээнд тэмцээнд 4.0 сая, "Хөдөлгөөн –эрүүл мэнд" арга хэмжээний хүрээнд ТББ-уудад 5.0 сая, Орхон аймагт зохион байгуулагдсан 21 аймгийн аварга шалгаруулах теннисний тэмцээнд оролцсон багт 2.0 сая, Жудо бөхийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчинд 0.5 сая, Бүх ард түмний XV наадмын сагсан бөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээний шагналд 2.8 сая, үйл ажиллагаанд 1.5 сая, Бүх ард түмний XV наадмын Баян-Өлгий аймагт зохион байгуулсан волейболын бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон баг тамирчдад 2.0 сая, Монгол улсын заан, харцага цолны урамшуулалд нийтдээ 36.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна.	50
3.3.2	Иргэдэд үйлчлэх нийтийн спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ		Шинээр байгуулагдсан спортын гадна талбай, тоглоомын талбайгаар хэмжинэ	Жилд нэг удаа	23	50	Аймгийн хэмжээнд нийтийн биеийн тамирын болон хүүхдийн гадаа тоглоомын талбай 35, тоног төхөөрөмжөөр хангагдсан бялдаржуулах кабинет 14 ашиглагдаж байна. 2021-2022 онд ЕБ-ын 10 сургууль бялдаржуулах кабинетыг байгуулж, тоног төхөөрөмжтэй болсон байна. (Алдархаан, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Завханмандал, Дөрвөлжин, Нөмрөг, Сантмаргаз, Түдэвтэй, Цагаанчулуут) 2022 онд Улиастай сумын ЕБ -ын 3-р сургуульд тоног төхөөрөмж авахад зориулж ОНХС -гаас 5,000,000 төгрөгийн дэмжлэгийг үзүүлж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Лаборатори Чандмань-Эрдэнэ цогцолбор сургуульд биеийн тамирын гүнзгийрүүлсэн сургалттай анги байгуулахад зориулж 5,000,000 төгрөгийн дэмжлэгийг ОНТ-өөс олгосон байна.	50
3.3.3	Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ		Чиглэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоогоор хэмжинэ	Жилд нэг удаа	520	1250	2022 онд НҮБ-ын Хүүхдийн сангаас 27.3 сая төгрөгийн дэмжлэгийг авч ажилласан. Аймгийн 32 цэцэрлэгийг хүүхэд, багш, ажилчдын танин мэдэхүйг дээшлүүлэх, хоол тэжээлийн талаар боловсрол олгох нөлөөллийн 3 төрлийн ханын самбар, хүнсээ нэрлэж сурах ач холбогдолтой, тархины хөгжлийг дэмжсэн 13.7 сая төгрөгийн тоглоомоор хангасан. Улиастай сумын ЕБ-ын сургуулиудын дунд "Цэх байя-Цэгцтэй хооллоо" уриан дор эрүүл хооллолтын талаарх мэдлэг, хандлагыг төлөвшүүлэх, мэдээллийг түгээх зорилго бүхий "Хөдөлгөөнт дасгал"-ын уралдааныг зохион байгуулсан. Улиастай сумын сургууль, цэцэрлэгийн 14 байгууллагын хоолны шим тэжээл, дээж авалтын байдалд үнэлгээг хийхэд цэцэрлэгийн хүүхдийн хоолны илчлэг 437-949 ккал, үдийн хоол 256-433 ккал байсан. Цаашид хүүхдийн хоолны илчлэгийг норм хэмжээнд хүргэх талаар зөвлөгөөг өгч, стандартын шаардлага хангахгүй хөргөгчтэй байсан 2 цэцэрлэг, 2 сургуульд дээжний хөргөгчийг шинээр олгосон. Эрүүл хооллолтын дадлыг бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилтын хүрээнд "Давс хэтрүүлэн хэрэглэх дадлаа зогсоо", "Ундны усны эрүүл ахуй", "Усны савны хэрэглээ", "Тэдэсний халдварт өвчин, түүнээс урьдчилан сэргийлье", "Өглөөний цайг уухын ач тус" зэрэг сэдвүүдээр 5152 иргэнд эрүүл мэдээлэл өгч, 470 ширхэг гарын авлага, материалыг тараасан. 18 сумын олон нийтийн цахим групп сүлжээгээр 16 төрлийн мэдээлэл, 5 төрлийн богино хэмжээний видео бичлэгийг байршуулж, 62855 хүн хандалт хийж, 160 удаа хуваалцсан байна. Хүнсний бүтээгдэхүүний шошгоны талаарх мэдлэг, хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, худалдан авалтын талаарх асуумж	50
3.3.4	Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна		Хамрагдсан иргэд	Жилд нэг удаа	58%	82%	2022 оны эцсийн байдлаар 25392 иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд, 14100 иргэнийг нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээнд хамруулж, 28533 хүн нийгмийн даатгалд хамрагдсанаас 3989 иргэн буюу 14.0 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна. Нийт давхардсан тоогоор 68025 иргэнд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Нийт хүн амын 92,1 хувийг эзэлж зорилгод түвшинг хангаад байна.	50

3.3.5	Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт, сувиллын газруудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ		Хамрагдсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	500	2000	Завхан аймгийн хэмжээнд "Отгонтэнгэр", "Улаан хаалга" рашаан сувилал нь уламжлалт, сэргээн засах чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Отгонтэнгэр рашаан сувилал нь 4-н улирлаар, Улаан хаалга рашаан сувилал нь улирлын чанартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Зуны улиралд Отгонтэнгэр рашаан сувилал 1080, Улаан хаалга рашаан сувилал нь 530 иргэнд үйлчилгээг хүргэсэн. Отгонтэнгэр рашаан сувиллын хоол үйлдвэрлэл үйлчилгээний байрыг хэсэгчлэн засах, амрагчдын 1-р байр, эмнэлгийн барилга, шавар эмчилгээний барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн амрагчдыг тээвэрлэх автобустай болсон. "Улаан хаалга"-ны рашааны найрлага, шинж чанарыг баталгаажсан лабораториор шинжлүүлэн дүгнэлтийг гаргасан. Рашааны ордыг бохирдол, хомсдолоос хамгаалах зорилгоор рашааны эрүүл ахуйн болон хориглолтын бүсийн хил, заагийг мэдэгдэхүйцээр тэмдэгжүүлж, хашиж хамгаалан, рашааны илэрс буюу ундарга, булгийн эх бүрийг тохижуулж, сэргээн засварлаж, мод тарьж, зүлэгжүүлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна. Улаан хаалга рашаан сувиллын төв замаас рашаан амралт хүртэлх замын засварын ажлыг гүйцэтгэхэд ОНХС-гаас 50,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж "Эко эвсэг" ХК ажлыг хийж гүйцэтгэсэн.	50
3.3.6	Бие бялдрын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ		Сорилд хамрагдалтын хувь	Жилд нэг удаа	17.6%	73.5%	Бие бялдарын сорилыг зохион байгуулж 3012 иргэн хамрагдсанаас 1400 хүүхэд байгаа бөгөөд сорилд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 46.5 байна. Мэдээлэл цахим системд шивэгдэж байна.	50
3.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								50.00
3.4. ХҮНД ЭЭЛТЭЙ ОРЧИН								
3.4.1	Өрхийн худалдан авах чадварт нийцсэн хямд өртөг бүхий орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ		Орон сууцаар хангагдсан өрхийн тоо	Жилд нэг удаа	50	100	2022 онд Улиастай сумын Богдын гол багт "Ар Си Ди" ХХК-ийн 86 айлын орон сууц, Жинст багт "Оч-Дөл өлзийт" ХХК-ийн 25 айлын орон сууцны барилгуудын угсралтын ажлууд эхлээд байна. 2022 онд Улиастай сумд 45 айлын орон сууц, Их-Уул, Идэр, Тэлмэн сумдад тус бүр 12 айлын орон сууцны барилгуудыг хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр барьж нийт 81 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан. Төрийн албан хаагчийн 8%-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулан хямд үнээр борлуулж байна.	50
3.4.2	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.		Хүн амын эзлэх хувь	Жилд нэг удаа	70%	85%	2021 онд Улиастай сумын 3 худаг, Сантмаргаз сумын 1 худаг, Тосонцэнгэл сумын төвийн 3 худагт цаг хугацаа харгалзахгүй картаар үйлчилдэг ухаалаг төхөөрөмж суурилуулсан. 2022 онд хайгуул хийж Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 3 худаг, Улсын төсвийн санхүүжилтээр 5 худаг гаргах төсөв батлагдсан боловч гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдаагүй төсөв хасагдсан. Түдэвтэй сумын шинэ суурьшлын бүсэд ОНТ-ийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр 1 худаг гаргаж, ухаалаг төлбөрийн систем суурилуулж байна. 2022 онд 10 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сумын усны сан бүхий газарт самбар, тэмдэг тэмдэглэгээ суурилуулах ажил хийгдсэн. Мөн Эрдэнэхайрхан сумын ундны усны худагт гадна цахилгаан эрчим хүч татах ажилд 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, ажлыг хийж ашиглалтад оруулсан. Мөн Түдэвтэй сумын сургууль, цэцэрлэгийн хэсэгт 1 худаг гаргасан. Улиастай сумын ногоон хашааны хэсэгт цэвэрлэх байгууламжийн 1 худаг гаргаж байна.	50
3.4.3	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.		Өрхийн эзлэх хувь	Жилд нэг удаа	24%	30%	2022 онд Их-Уул, Тэлмэн, Идэр Түдэвтэй, Сонгино сумдад тус бүр 12 айлын орон сууц, Улиастай сумын Богдын гол багт "Ар Си Ди" ХХК-ийн 86 айлын орон сууц, Жинст багт "Оч Дөл өлзийт" ХХК-ийн 20, Өндөр говь мэргэн 17 айлын үйлчилгээтэй орон сууц, "Алтан харш" ХХК-ийн 13 айлын орон сууц, Богдын гол багт иргэн Санжмятавын 9 айлын орон сууцны барилгуудын угсралтын ажлууд эхлээд байна. Завхан аймгийн хэмжээнд 2022 онд нийт 205 айлын нийтийн орон сууцны барилга баригдаж эхэлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар Улиастай сумд 45 айлын орон сууц, Их-Уул, Идэр, Тэлмэн сумдад тус бүр 12 айлын орон сууцны барилгуудыг хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр барьж нийт 81 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан.	50
3.4.4	Аймаг, сумын төвийн өрхүүдээс нэгдсэн халаалтанд холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ.		Халаалтанд холбогдсон өрхийн эзлэх хувь	Жилд нэг удаа	12%	20%	Аймгийн хэмжээнд 19 сум нь 2014-2020 оны хооронд нэгдсэн дулааны эх үүсвэрт холбогдсон дулааны шугамтай зэрэгцэн цэвэр усны ундны эх үүсвэрт холбогдоод байна. 2024 онд дулааны станц ашиглалтад орохтой холбогдуулан нэгдсэн халаалтад холбогдох өрхийн тоо нэмэгдэнэ. Сумдыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендер барилга хот байгуулалтын яаманд зарлагдаж Сонгино Түдэвтэй сумыг Сонголт дизайн ХХК, Тэс Цагаанхайрхан сумын зураг төслийг Консалтинг ХХК, Дөрвөлжин сумыг Инженер геодези ХХК тус тус гүйцэтгэгчээр шалгарсан боловч төсвийн тодотголоор хөрөнгө хасагдсан. 2021 онд төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд Яруу сум холбогдож, 2022 онд төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд Их-Уул сум холбогдож, ашиглалтад орсоноор Завхан аймгийн 23 сум төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд холбогдоо. Шинэ сум төслийн хүрээнд Отгон сумд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ хийгдэж байна. Айл өрх, албан байгууллагуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломж нөхцөл бүрдээд байна.	50

3.4.5	"Шинэ сум" төслийг хэрэгжүүлж, сумын төвүүдийг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно		Байгууламжийн тоо	Жилд нэг удаа	3	6	Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд 2022 онд Алдархаан, Отгон суманд шинээр 50м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил хийгдэж байна. Сумдад үе шаттайгаар цэвэрлэх байгууламжийг шинээр барих шаардлагатай байгаа тул сумдын бохир усны хоногийн хэрэглээ, ариутгах татуургын ашиглалтын байдлыг харгалзан үзэж эрэмбэлж цэвэрлэх байгууламж нэн түрүүнд шаардлагатай сумдын нэрсийг БХБЯ-нд хүргүүлсэн. Улиастай суманд Польш улсын ЗГ-ын зээлээр хоногт 3000м3 цэвэрлэх хүчин чадалтай ариун цэврийн байгууламж баригдахаар гүйцэтгэгч шалгарч 2022 оны 09 сарын 21-нд угсралтын ажлыг эхлүүлэх нээлтийн арга хэмжээ болсон. Мөн аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд 13 сум хамрагдсан үүнээс 8 сумын сургууль, цэцэрлэг дотуур байрны барилгын ариун цэврийн байгууламжийн ажлыг хүлээлцэх комисс ажиллаж, ашиглалтад оруулсан.	50
3.4.6	Сум, суурин газруудын ногоон байгууламжийн эзлэх талбайг нэмэгдүүлж, соёл амралтын хүрээлэн байгуулна.		Ногоон байгууламжийн талбай	Жилд нэг удаа	12.6	38.0	2022 онд Улиастай сумын Богдын гол багт хүүхдийн парк, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд Орон нутгийн төсөвт 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдвэрлэсэн. Ажлын зураг төсвийг хийлгэж байна. Мөн Улиастай сумын Богдын гол багт Гудамж төслийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил 2.2 га газарт ногоон байгууламж, зүлэг, мод тарьсан. Бусад тохижилтын ажлыг Төгс зам ХХК хийж байна. Тосонцэнгэл сумд 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр соёл амралтын хүрээлэнг Зост-Өргөө ХХК гүйцэтгэсэн.	30
3.4.7	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна		Үйлчилгээгээр хангагдсан иргэдийн хувь	Жилд нэг удаа	2%	25%	Хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд "Жавхлантай хийморь", "Гранд автобус" ХХК, "Хараацайн жигүүр" ХХК-ийн том оврын автобусууд үйлчилдэг бөгөөд замнал зураглалын дагуу сумдын зорчигчид үйлчлүүлдэг цахимаар бичүүлэх, зорчих тасалбар авч үйлчлүүлж байна. Бусад сумдын зорчигчид шуудан үйлчилгээний автомашин болон хувийн тээврийн хэрэгслээр зорчиж байна. 2022 онд Улиастай суманд нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулахаар Солонгос улсаас 70.0 сая төгрөгийн өртөг бүхий дунд оврын автобусыг "Мөнгөн трейд" ХХК нийлүүлэхээр болсон.	30
3.4.8	Үерийн эрсдэлээс хамгаалагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ		Байгууламжийн тоо	Жилд нэг удаа	0	3	Улиастай сумын Богдын гол багт 1.5 км урт үерийн усны далан байгуулах ажлын зургийн даалгавар боловсруулан БХБЯ-нд хүргүүлж, 2020 оны 11 сарын 20-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газарт ажлын зураг төсөв боловсруулах тендер зарлагдаж "Их мянган инженерчлэл" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэсэн. 2021 онд БХБ сайдын багцаас хөрөнгө батлагдаж Жаргалант, Чигэстэй багт 5км үерийн усны далан байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгавар хүргүүлж төрийн худалдан авах ажиллагааны газарт тендер зарлагдаж "Гидросоружение" ХХК шалгарч ажлын зураг төслийг гүйцэтгэж БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. Тус ажлуудыг гүйцэтгэхэд 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу хөрөнгийн асуудлыг шийдвэрүүлэхээр 2022 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч санхүүжилт шийдэгдээгүй дахин 2023 оны Улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрүүлэхээр 2022 оны 05 сарын 01-ны өдөр БХБЯ-нд санал хүргүүлсэн.	50
3.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								45
3.5. ГАЗРЫН ХАРИЛЦАА								
3.5.1	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.		Төлөвлөгөө боловсруулагдсан сумын тоо	Жилд нэг удаа	3	6	2022 оны Төсвийн тухай хуулийн XII.4.10 заалтанд Сумдыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө / Сонгино, Тэс, Цагаанхайрхан, Дөрвөлжин, Түдэвтэй/ сумдуудад хийгдэхээр 800.0 сая төгрөгийн төсөв тусгагдсан. Барилга, хот байгуулалтын яаманд тендер зарлагдсан ч 2022 оны төсвийн тодотголоор хөрөнгийн асуудал хасагдсан. 2022 оны байдлаар Завхан аймгийн 24 сумаас 4 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байна. 2022 онд сум хөгжүүлэх сангийн тус бүр 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна.	30
3.5.2	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлнэ		Зах зээлийн үнийн мэдээ болон газрын дуудлага худалдааны тоо	Жилд нэг удаа	823	5851	Нийт 15135 нэгж талбарт 560 сая төгрөг төлөвлөж 759.7 сая төгрөгийн ногдуулалт хийж 698.2 сая төгрөг нэхэмжилж 569 сая төгрөг төвлөрсөн, төлөвлөгөөний өсөлт 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 58.9 % байна. Ногдуулалтын өсөлт - 90%, Орлогын өсөлт өмнөх оны энэ үеэс 76.3 %-тай байна. 2022 онд нийт 22 сумын 391 байршилд 2649 га газарт дуудлага худалдаа төлөвлөж цахимаар 391 байршлын 152 байршилд 1579 га газар олгож, дэнчин-25.3 сая, орлого-305 сая, оролцогч-446 хүн оролцсон байна.	50

3.5.3	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг боловсруулна.		Төлөвлөлтөнд орон зайн төлөвлөлт ашигласан сум, байгууллагын тоо	Жилд нэг удаа	17	41	2019 оны 05 дугаар сард БХБЯ, Барилгын хөгжлийн төвийн Хүн амын нутагшилт суурьшлын бүс нутгийн төлөвлөлтийн хэлтсээс төслийн бүрэлдэхүүн холбогдох байгууллага, албан тушаалтан 54 хүнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр төслийн талаар танилцуулж төсөлд оруулах саналыг нэгтгэн авсан. Ажлын хэсгийг холбогдох мэдээлэл судалгаагаар хангах үүднээс орон нутгийн холбогдох байгууллагуудаас 35 төрийн хүснэгтийн дагуу судалгаа гаргуулж нэгтгэн 2020 оны 06 сарын 13-ны өдөр төслийн багт хүргүүлсэн. Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах сургалтад холбогдох мэргэжилтнийг оролцуулж мэдээлэлтэй болгосон. Мөн 2022 оны 3-р сард барилгын хөгжлийн төвөөс орон нутгийн холбогдох хүмүүсийг оролцуулан 2 дахь удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2022 онд Орон нутгийн сумдын удирдлага, албан байгууллагын холбогдох хүмүүсийг хамруулсан хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулж, холбогдох санал, судалгааг хүргүүлсэн. Орон нутгаас шаардагдах бүх судалгааг хүргүүлсэн. БХБЯам хариуцан боловсруулж, батлуулна.	30
3.5.4	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг үе шаттай боловсруулна		Сумын тоо	Жилд нэг удаа	3	6	2022 онд "Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь" төсөлтэй хамтран Алдархаан, Эрдэнэхайрхан, Отгон сумдад нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг БОАЖЯ тендерийг зарлаж "Лал ланд эко" ХХК шалгарч хэргийн судалгааг хийж, боловсруулалтын үе шатандаа хийгдэж байна. 2022 онд Дөрвөлжин, Цэцэн-Уул, Тосонцэнгэл, Их-Уул 4 сумд төлөвлөгөө боловсруулсан хэрэгжиж байна. 2023 онд Баянтэс, Баянхайрхан, Идэр, Нөмрөг, Цагаанчулуут, Завханмандал, Сантмаргаз, Яруу, Тэс 9 сумд хийхээр санал хүргүүлсэн.	50
3.5.5	Сумдад хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ		Стандартын хаягжилт хийгдсэн өрхийн тоо	Жилд нэг удаа	14	24	Хаягийн зураг, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2017 онд хүлээн авснаас хойш сумдууд хаягийн зураг, мэдээллийн сангийн шинэчлэлтийг хийж, нийтлэг зөрчил их байгаатай холбогдуулан хаягийн мэдээлэл шалгах, засварлах ажлыг төлөвлөгөөний дагуу удирдамж гарган 24 сумын хаягийн мэдээллийн сан барилга 76.5 хувь, нэгж талбар 62.5 хувьтай хийгдэж байна.	30
3.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								38
ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮН								39.85
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ								
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР								
4.1								
4.1.1	Макро эдийн засгийг хөгжлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ		Хувиар	Жилд нэг удаа	7%	3%	2022 оны ургац хураалтын мэдээг өнгөрсөн онтой харьцуулахад төмс 621.6 тн буюу 29.3 хувь, таримал тэжээл 7840.8 тн буюу 62.2 хувь, үр тариа 1003.0 тн буюу 57.2 хувь, хүнсний ногоо 390.2 тн буюу 24.5 хувиар тус тус буурч байгалийн хадлан 1322.7 тн буюу 7.2 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн өнгөрсөн оноос 5.8 хувиар буюу 1 тэрбум 542.1 сая төгрөгөөр өссөн байна. Үйлдвэрлэлд 25.3 хувийг цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл, 21.3 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 53.4 хувийг бусад үйлдвэрлэл тус тус эзэлж байна.	30
4.1.2	Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна		Эдийн засгийн салбаруудын бүтэц ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Жилд нэг удаа	32.5%	48.0%	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2022 онд 28 тэрбум 40.7 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 5.8 хувиар буюу 1 тэрбум 542.1 сая төгрөгөөр өсч, нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 23 тэрбум 267.6 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 4 тэрбум 773.2 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд 25.3 хувийг цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 21.3 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 53.4 хувийг бусад үйлдвэрлэл тус тус эзэлж байна.	30
4.1.3	Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ		Төсвийн орлого	Жилд нэг удаа	7,670	9,858	2022 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн татварын орлого төлөвлөгөөгөөр 13.9 тэрбум төгрөгөөс 16.5 тэрбум орлого төгрөгний орлого орж татварын орлого давж биелсэн байна.	100
4.1.4	Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна		Төсвийн зардал	Жилд нэг удаа	22,152	22,747	2022 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 60.6 тэрбум төгрөгөөс 49.9 тэрбум төгрөгний зарлага гарсан байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэгдэх зардалуудыг хэмнэж ажилласан.	100
4.1.5	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ, экспортыг нэмэгдүүлнэ.		Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	Жилд нэг удаа	3,094.50	5,453.57	"ЭДГС" ХХК нь 2022 оны эцсийн байдлаар үйлдвэрийн аргаар бэлтгэсэн 310 тн адууны махны нөөцтэй байна, 2022-2023 онд ОХУ-д адууны мах 800 тн, үхэр, хонины мах 1500 тн-ыг гаргахаар гэрээ байгуулсан, үхэр, хонины махан дээр экспортын зөвшөөрөл гараагүй хүлээгдэж байна. 2022 онд "Эрдэнэт мах маркет" ХХК Тосонцэнгэл сумын "Мах маркет" ХХК-тай мал мах нийлүүлэх гэрээ хийж 35 тонн мах нөөцлөөд байна.	50

4.1.6	Орон нутаг дахь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.		Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаар хэмжинэ	Жилд нэг удаа	4,373.60	7,043.73	Хүн амын хүнсний хэрэгцээнд хөдөө аж ахуйгаас 55.4 мянган литр сүү, 22.1 тн цагаан идээ хүн амын хүнсний хэрэгцээнд худалдан борлуулагдаж байна. Сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 7 сумын 27 иргэн аж ахуйн нэгж жилд дунджаар 6000-8000 литр сүү бэлтгэн зах зээлд нийлүүлж нийт хүн амын сүүний хэрэгцээний 3.2%-ийг хангаж, бусад хувийг хөдөө аж ахуйгаас буюу өрхийн үйлдвэрлэлийн түвшинд бэлтгэгдсэн сүү цагаан идээгээр хангаж байна.	50
4.1.7	Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.		Малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын орлого	Жилд нэг удаа	23,247	37,716	Завхан аймгийн хэмжээнд мах боловсруулах чиглэлээр "Завхан хүнс" групп, "Завхан Мах маркет" ХХК, "Тэс –Шим" хоршоо, "ЭДГС" ХХК үйл ажиллагаа явуулж байна. Ноос, эсгий үйлдвэрлэх чиглэлээр "Эрхэт тунамал" ХХК, арьс шир боловсруулах, элдэх чиглэлээр "Булган сор хишиг" ХХК үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн аж ахуйн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд арьс, ширэн үйлдвэрлэл 1.9 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.8 хувь, эсгий, эсгий эдлэлийн үйлдвэрлэл 2.1 хувийг эзэлж байна.	50
4.1.8	Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурласан хөнгөн үйлдвэрүүдийг байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно.		Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хэмжинэ	Жилд нэг удаа	2,436	4,899	2022 онд Улиастай сумын Өлзийт багт хоногт 1000м3 зуурмаг нийлүүлэх хүчин чадалтай зуурмагийн үйлдвэр шинээр байгуулсан.	50
4.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								57.50
4.2	БИЗНЕС ЭРХЛЭХ ТААТАЙ ОРЧИН							
4.2.1	Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ		Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	Жилд нэг удаа	25,980	39,281	Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангаас нийтийн хоол, худалдаа үйлчилгээ, сүү, цагаан идээ, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тахиа, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 3 сумын 5 аж ахуйн нэгж, 1 хоршоонд 125 сая төгрөгийн зээл олгосон. Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон баталгаажуулалтын зөвлөл сар бүр 2-3 удаа хуралдаж 2022 оны 11 сарын байдлаар нийт хүнсний худалдаа эрхлэгч 235 аж ахуйн нэгжид шинээр болон хугацаа сунгалт хийн тохирлын гэрчилгээ олгосон, 84 аж ахуйн нэгжийн 8 нэр төрлийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээг олгож үйл ажилгааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Сумдад үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүрүүдтэй хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, хадгалалтын горим, тээвэрлэлтийн байдал зэргийг төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулах тал дээр хамтран ажиллаж хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн мэдээг хүргүүлж байна. Хүнсний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгаас махны чиглэлийн герефорд үүлдрийн бухыг авчирж ХХАА-н газарт бүртгэсэн.	50
4.2.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нийлүүлэх тээвэр, логистикийн төвүүдийг томоохон хотуудад байгуулна		Баигуулагдсан агуулах худалдааны төвөөр дамжуулан борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ	Жилд нэг удаа	0	400.0	Улиастай суманд "Эм АрЭм Эс" ХХК нь 500м2 талбай бүхий Баян бүрд агуулах худалдааг барьж УБ хотын 8 томоохон бөөний төвүүдтэй гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлэхээр тохирлын гэрчилгээ олгогдсон байна. Агуулах худалдаа нь 24 суманд бөөний бараа бүтээгдэхүүнийг агуулахаас шууд тээвэрлэх үйлчилгээг эрхэлнэ.	50
4.2.3	Орон нутгийн давуу талыг түшиглэн зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ.		Хөрш зэргэлдээ улс, аймгуудтай хийсэн худалдааны хэлэлцээр, гэрээ, бий болсон сувгийн тоо	Жилд нэг удаа	0	15	Хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Завхан Баялаг" ХК үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Улаанбаатар хотод хүнсний дэлгүүрүүдээс захиалга авч гэрээ байгуулан худалдан борлуулж байна. Номин Холдинг ХХК-ийн 21 аймаг 21 брэнд бүтээгдэхүүн арга хэмжээний хүрээнд "Мөнхөд Мандаг" ХХК гэрээ байгуулан Номин сүлжээ дэлгүүрт 6-7 төрлийн бүтээгдэхүүнийг борлуулах эрхтэй болсон	50
4.2.4	Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийн салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ		Санхүүжилтийн хэмжээ	Жилд нэг удаа	50	500	Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 28 дугаар "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц санд 1,365,200,000 төгрөг. Үүнээс Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 –ны өдрийн 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.2 дугаар заалтад заагдсан арга хэмжээнд зарцуулах 409,560,000 төгрөг тусгагдсан. Мөн аймаг, сумын 2022 оны төсөвт гамшагаас урьдчилан сэргийлэх, онцгой байдлын байгууллагын чадавхыг дээшлүүлэх хүрээнд нийт 90,340,000 төгрөгийн төсвийг тусгуулсан байна. Улсын Онцгой комиссын ажлын албанд хагас бүтэн жилээр хөрөнгө зарцуулалтын тайланг гаргаж хүргүүлэн ажиллаж байна.	70
4.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								55
4.3	БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН							
4.3.1	Технологи, мэдээллийн паркад суурилсан ХАА, барилгын салбар, биотехнологийн туршилтийн лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлнэ		Туршилтаар хийгдсэн бүтээгдэхүүний тоо	Жилд нэг удаа	0	25	2022 онд ГХБХБГ-ын барилгын материалын лабораторит Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 50.0 сая төгрөгийн өртөг бүхий холбогч материалын лабораторийн нийт 20 нэр төрлийн тоног төхөөрөмжийг "Ариун мед трейд" ХХК гүйцэтгэгчээр шалгаран нийлүүлсэн. 2022 онд Барилга угсралтын 16 аж ахуйн нэгжид бетон сорьц 129, элсний шинжилгээ 3, хайрганы шинжилгээ 4, тоосгоны шинжилгээ 2-ыг хийгээд байна.	50

4.3.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ		Завхан аймгийн брэнд бүтээгдэхүүний хөгжүүлэлт, технологижуулалта нд зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Жилд нэг удаа	400	1,200	Хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Мөнхөд мандаг" ХХК, "Завхан баялаг" ХК 20 нэр төрлийн бүтээгдэхүүн, орон нутгийн бэлгийн багц, брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж хүнсний хэрэгцээнд Улаанбаатар хот, аймагтаа худалдан борлуулж байна.	50
4.3.3	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ		Худалдан авалтанд эзлэх хувь	Жилд нэг удаа	12%	50%	Дотоодын үйлдвэрүүдээс 8 төсөл, арга хэмжээнд 17 төрлийн 402.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж худалдан авч жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжин ажилласан.	50
4.3.4	Дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна		Боловсруулсан бүтээгдэхүүний хэмжээ	Хагас жилд нэг удаа	0	50	Дахивар хог хаягдлыг шахаж нягтаршуулах төхөөрөмжийг "Завхан Ногоон Гарц" ТББ-аас шилжүүлж авсан Тосонцэнгэл сумын иргэн А.Уламбаяр одоогоор хуванцар цуглуулах шатанд үйл ажиллагаа нь явагдаж байна.	50
4.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								50.00
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН								54.17
ТАВ. ЗАСАГЛАЛ								
5.1 УХААЛАГ ЗАСАГЛАЛ								
5.1.1	Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ		Төрийн үйлчилгээг цахимаар авсан иргэдийн хувь	Жилд нэг удаа	15%	60%	Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор 24 сумын Засаг даргын Тамгын газарт E-Mongolia операторын үйлчилгээг 100 хувь нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд аймаг, сумын ЗДТГ, Архивын тасаг, ТАЗСЗ, УБХ, ГХБХБГ, Татварын хэлтэс зэрэг байгууллагууд давхардсан тоогоор 12000 гаруй иргэнд төрийн үйлчилгээг цахимаар хүргэсэн байна.Түүнчлэн E-mongolia цахим үйлчилгээний төвийг Улиастай суманд нээж, давхардсан тоогоор 5000 иргэдэд үйлчилгээ үзүүлээд байна. Мөн цахим жишиг аймаг болох зорилтын хүрээнд 24 сумын e-mongolia үйлчилгээ үзүүлдэг операторуудад арга зүйн зөвлөгөө өгөх, тоон гарын үсгийн хугацаа дууссаныг Үндэсний дата төвд сунгуулах ажлыг зохион байгуулсан. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх, Тоон гарын үсгийг иргэдэд олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор УБХ-ээс төрийн байгууллагын албан хаагчдыг тоон гарын үсэгт хамруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран e-mongolia цахим системд орон нутгийн олон шатлалт 15 байгууллагын 50 үйлчилгээг шинээр нэвтрүүлэн ажилласан. Мөн иргэд, төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох сургалтыг танхимаар болох цахимаар зохион байгуулж, цахим төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг оролцуулан "Нээлттэй хаалганы өдөрлөг", аймгийн цагдаагийн газартай хамтран "Иргэдээ сонсьё" аянд цахим үйлчилгээг сурталчлах ажлууд хийсэн.	30
5.1.2	Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан чадавхжуулна		Төрийн байгууллагын тоо	Жилд нэг удаа	5	42	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И Монгол академитай хамтран Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн egr. e-mongolia портал системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын дэргэдэх 13 хэлтэс агентлаг, 6 сумын ЗДТГ, төрийн байгууллагууд нэвтрүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Системтэй холбоотой сургалтыг төрийн албан хаагчдад тогтмол хийж, заавар зөвлөгөө өгч байна Цахим ур чадвар олгох сургалтыг давхардсан тоогоор 24 сумын 550 гаруй төрийн захиргааны албан хаагчдад танхимаар, 200 гаруй албан хаагчдад цахимаар зохион байгуулсан.	50
5.1.3	Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ		Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хувь	Жилд нэг удаа	60.5%	61.5%	Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхээр 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал хүргүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй.	30
5.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								36.67
5.2 УХААЛАГ БҮТЭЦ								

5.2.1	Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгоно		Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Жилд нэг удаа	80.0	105.0	Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгох зорилгоор аймгийн Засаг дарга, удирдлагууд сумдад ажиллаж, ард иргэдийн зүгээс гарсан хүсэлт, санал бодлыг сонсож, бодлого, төлөвлөгөөндөө тусган шийдвэр гарган ажиллаж байна. Иргэдийн санал, хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 70461212 дугаарын утсаар хүлээн авахаас гадна аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар дамжуулан санал, хүсэлтийг хүлээн авч байна. 2022 онд нийт 364 иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгсөн. Цахилгаан холбооны Завхан аймаг дахь салбартай хамтран Төрийн байгууллагуудад CALL CENTER цахим утас нэвтрүүлж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж байна.	30
5.2.2	Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ		Хамтран ажиллахаар байгуулсан гэрээний тоо	Жилд нэг удаа	10	65	Аймгийн Улаан загалмайн хороо, Нэг цэгийн үйлчилгээний төв, аймгийн ахмадын холбоо, "Эрэгтэйчүүдийн холбоо", "Эмэгтэйчүүдийн холбооны Завхан салбар" ТББ, "Очирвааний Боломж" НҮТББ, "Өрнөх хөгжил сүлжээ" ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар холбоо, Хараагүйчүүдийн холбоо зэрэг байгууллагуудтай хамтран төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлж байна. Хамтын ажиллагааны хүрээнд 63.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцууллаа.	50
5.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								40.0
5.3 ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА								
5.3.1	Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ		Нийгмийн асуудлыг хангахад зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн	Жилд нэг удаа	15.0	40.0	Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, ёс зүй, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн, аймгийн Засаг даргын захирамжаар 2022 оныг "Завхан аймгийн төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон зарлаж, төлөвлөгөө гарган хэрэгжүүллээ. Зарласан жилийн хүрээнд төрийн байгууллагуудын тайланг хүлээн авч, "Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг өндөржүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр шинэлэг ажил зохион байгуулж, санал санаачилга гаргасан" байгууллагуудыг шалгаруулахаар 1 сарын хугацаатай аян зарлаж шилдэг байгууллага, ёс зүйн зөвлөлийг шагнаж урамшууллаа. Түүнчлэн Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, төсвийн шууд захирагч нарт төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн дотоод журманд тусгаж, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгч, хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2022 онд төрийн байгууллагуудын дунд аян зарлаж, үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Энэхүү аяны хүрээнд төрийн байгууллагуудаас ирүүлсэн тайлан мэдээг үндэслэн "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах, сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэлэг ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж буй санал, санаачилга" зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан үнэлгээ хийж, дүнг гаргалаа. Үнэлгээний дүнгээр: Нэгдүгээр байр - Прокурорын газар - өргөмжлөл, 3,000,000 төгрөг, Хоёрдугаар байр - Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг - өргөмжлөл, 2,000,000 төгрөг, Гуравдугаар байр - Зооносын өвчин судлалын төв - өргөмжлөл 1,000,000 төгрөг, Тусгай байр – Политехникийн коллеж – өргөмжлөл, 500,000 төгрөгөөр шагнагдлаа. Нэрлэсэн жилийн хүрээнд төрийн албан хаагчийг чадавхжуулах, харилцан туршлага солилцох зүүн бүсийн сургалтыг Их-уул суманд, хойд бүсийн сургалтыг Түдэвтэй суманд тус тус зохион байгуулж, 300 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа.	50
5.3.2	Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна		Сургалтанд хамрагдсан ТАХ-ийн тоо	Жилд нэг удаа	5,299	10,500	Төрийн байгууллагууд Төрийн албаны тухай хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар болон аймаг, орон нутгаас дэвшүүлсэн бодлого, зорилтын хүрээнд төрийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2022 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 онд Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 10, дунд хугацааны давтан сургалтад 20, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 18, богино хугацааны сургалтад 42, нийт 91 албан хаагч цахим хэлбэрээр хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлээ. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7 хоног бүрийн "Пүрэв" гарагийн сургалтад хэлтэс, агентлагийн дарга нар болон аймаг, сумдын ЗДТГ-ын дарга мэргэжилтнүүдийг хамруулан энэ ажил тогтмолжсон. Тайлант онд нийт давхардсан тоогоор 5000 гаруй төрийн албан хаагч танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна.	50
5.3.3	Авлигаас ангид аймаг байна		Авлигын индекс	Жилд нэг удаа	81.1%	92.0%	Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасан "авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх", мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасан "төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх" чиг үүргийн хүрээнд 5 дахь удаагийн буюу 2021 оны "Шударга байдлын үнэлгээ"-гээр Завхан аймаг 68.2 үнэлэгдсэн. Иймд Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэн ажиллах шаардлагатай гэж үзэн 2022 онд 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээ төлөвлөн ажиллаж, хэрэгжилт 95 хувьтай ажилласан.	90
5.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								63.33

ТАВДУГААР БҮЛГИЙН ДҮН								46.67
ЗУРГАА: НОГООН ХӨГЖИЛ								
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ								
6.1	Онцлог экосистем бүхий газар нутгийг тусгай хамгаалалтанд авна		Нийт тусгай хамгаалалттай газар нутаг	5 жилд нэг удаа	42.5%	46.5%	2022 онд 4496.67 га талбай бүхий 5 газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний талбай 4070177.9 га талбай болж нийт газар нутгийн 49.3%-ийн эзэлж байна.	70
6.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								70
БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ								
6.2	Амьтны нөөцийг хамгаална		Хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээ	Жилд нэг удаа	7	16	Эрдэнэхайрхан, Тосонцэнгэл, Тэлмэн, Дөрвөлжин, Отгон, Шилүүстэй сумдад 8 цэгт 33 боодол өвс, 21 уут хужир тавьж биотехникийн арга хэмжээ авч ажиллалаа. Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн "Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх тухай" 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж, хууль бусаар нэн ховор болон ховор хонин арц түүх явдлыг таслан зогсоох зорилгоор Алдархаан сумын нутагт 6 цэгт 6 автомат камерыг байршуулан хяналт тавьж байна. Тэлмэн, Тосонцэнгэл, Цагаанхайрхан, Улиастай сумдын 13 иргэний 80 толгой тарвагыг хураан авч устгал хийж 27 980 000 төгрөгийн нөхөн төлбөр, 3 900 000 төгрөгийн торгууль ноогдуулсан.	50
6.2.2	Нэн ховор, ховор ургамлын генетикийн нөөцийг хамгаалж, ашиглалтын нөөц бий болгоно		Хамгаалагдсан зүйл	Жилд нэг удаа	26	26	Арцны нөөц тогтоох судалгааны ажлыг "Отгон бор хавцал" ТББ-аар гүйцэтгүүлж байна. Алдархаан сумын Богдын гол багийн чиглэлийн судалгаа, ургамлын зүйл тогтоох, ДРОН ашиглан сансраас зураг авах ажлыг 8-9 сард 2 удаа хийсэн. "Хуульчийн робото 2022" өдөрлөгт байгаль орчны багц хууль шинээр мөрдөгдөж буй дүрэм журмыг иргэн аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан 355 ширхэг хуулийн эмхэтгэл гарын авлага, говийн гайхамшигт-6 амьтныг олон нийтэд таниулах зорилгоор 85 ширхэг ном тараасан. Дэвшил сургуулийн 2а ангийн 37 сурагчид ГГ-6 амьтныг танилцуулан ном тарааж экологийн боловсрол олгосон. Нийт 477 иргэнд сурталчилсан.	30
6.2.3	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ		Ойгоор бүрхэгдсэн талбай	Жилд нэг удаа	6%	6.10%	Тосонцэнгэл сумын Оргих багийн Дунд өвөлжөө нэртэй газрын ойн сангийн 50 га талбайд, "Ургах нахиа" ХХК шилмүүст модоор ойжуулалт, Рашаант баг Агьтийн намаржаа нүүр нэртэй газрын 50 га талбайд "Хавчгийн ногоон мод" ХХК байгалийн сэргэн ургалтад туслах ажил, Оргих багийн Идэр голын сав дагуу 4 га талбайд "Отгон баян уул" ХХК навчит модоор ойн төгөл, Их-Уул сумын нутаг Идэр голын сав дагуу 5 га талбайд "Хавчгийн ногоон мод" ХХК ойн зурвас байгуулах ажлыг тус тус гүйцэтгэсэн.	50
6.2.4	Ойн сангийн төлөв байдлыг сайжруулна		Шатсан ойн талбайн хэмжээ	Жилд нэг удаа	133	124	Тосонцэнгэл сумын ойн сангийн 50 га талбайд "Сайхан ой" ХХК 1, 2 дугаар ангийн ойд арчилгааны огтлолт, 50 га талбайд "Ургах нахиа" ХХК ойжуулалтын ажил, 50 га талбайд "Хавчгийн ногоон мод" ХХК байгалийн сэргэн ургалтад туслах ажил, 30 га талбайд арчилгааны ажил ойн санг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлүүд, Идэр сумын ойн сангийн 89 га, Тосонцэнгэл сумын ойн сангийн 200 га нийт 289 га талбайд "Зулзан мод төгөл" ХХК ойн цэвэрлэгээний ажил, Баянтэс, Баянхайрхан сумын ойн сангийн 1000 га талбайд "Хатант форест" ХХК ойн хөнөөлт шавжтай тэмцлийн ажил тус тус хийж гүйцэтгэсэн.	50
6.2.5	Усны нөөцийн бохирдол, хомсдлоос сэргийлнэ		Хамгаалалтын бүсийн дэглэм	Хагас жилд нэг удаа	80%	95%	17 сумын 30 уст цэгийг тэмдэгжүүлсэн. Дөрвөлжин сумын Сайн түрүү, Тосонцэнгэл сумын Хүрэн булгийн эх, Отгон сумын Сайн булаг, Ургамал сумын Баян-Улаан, Яруу сумын Рашаан толгойн рашааныг хамгаалж, тохижуулах ажлыг "Баян ангирт нуур" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хүлээн авсан. Усны сан бүхий газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 20 гаруй гол, булаг, шандны 200 км орчмын хог хаягдлыг нийт 11 техник хэрэгсэл, 300 төрийн албан хаагчид цэвэрлэж 23 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгасан.	50
6.2.6	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн механизмыг хэрэгжүүлэх замаар нөөцийн зохистой ашиглалт, хамгааллыг сайжруулна		Хөрөнгийн зарцуулалт	Жилд нэг удаа	11%	60%	2022 онд байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 457.6 сая төгрөг төлөвлөн 94%-ийг зориулалтын дагуу зарцуулж 19 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	90
6.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								53.33
ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН								
6.3								

6.3.1	Эвдэрсэн доройтсон газар нутгийг сэргээнэ		Талбай	Жилд нэг удаа	15.64	31.31	Тосонцэнгэл суманд замын карьерийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 4 га талбайг дүйцүүлэн хамгааллын хүрээнд "Баян-Айраг эксплорэйшн" ХХК болон "Шувуун хар уул" ХХК нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байна.	50
6.3.2	Байгаль эзлэлтэй технологи нэвтрүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна		Орчны бохирдол	Жилд нэг удаа	30%	10%	Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Улиастай суманд 3000куб.м/хоногийн хүчин чадалтай төв цэвэрлэх байгууламжийн зураг төслийн ажил хийгдсэн, 2023 оноос төслийн ажил эхлэхээр төлөвлөж байна. Бүгд найрамдах Солонгос улсын хөнгөлөлттэй зээлээр Улиастай суманд 25 Гкал/цагийн хүчин чадалтай Дулааны станцын барилга угсралтын эхэлсэн. Дулааны станц баригдсанаар Улиастай сум хэрэглээний халуун усаар бүрэн хангагдаж, агаар бохирдуулагч 11 уурын зуухны үйл ажиллагаа зогсож, дулаан дамжуулагч болно. Улиастай сумын агаарын чанар, төлөв байдлын судалгааг хийж агаарын чанарыг сайжруулах бүсийн төслийг боловсруулан Улиастай сумын Жинст, Жаргалант, Чигэстэй багуудад хэлэлцүүлэг зохион байгуулсан. Улиастай суманд агаар бохирдуулах эх үүсвэр хүлцэх хэмжээнээс даваагүй байна.	70
6.3.3	Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ		Зөрчил	Жилд нэг удаа	44	0	Завханмандал суманд ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Шувуун хар уул" ХХК, Ургамал суманд ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй "Форс голд майнинг" ХХК-д хяналт шалгалт хийж нийт 30 зөрчил илрүүлж, Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, зөрчлийг 100% арилгуулсан.	50
6.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								56.67
6.4	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧӨЛТ							
6.4.1	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ		Эзлэх хувь	Жилд 6 удаа	29%	95%	Аймгийн хэмжээнд цаг агаарын хуурайшилтыг бууруулах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 4 дүгээр сарын 10-аас эхлэн нийт 10 удаа, газрын генератор 3 удаа нийт 13 удаагийн үйл ажиллагаа явуулсан. Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээллэх, сэрэмжлүүлэх зорилгоор нийт 105 удаа АНХААРУУЛГА, 8 удаа СЭРЭМЖЛҮҮЛЭГ, 5 удаа УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ мэдээ зохиож, олон нийтийн сүлжээ болон багц мессежээр ард иргэдэд шуурхай хүргэж ажилласан. Багц мессежээр нийт 19 удаа (шар ус, хүйтэн бороо, их бороо, цочир хүйтрэлт, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи зэргээр) 192000 хүнд хүргэж үйлчилсэн байна. Цаг агаарын мэдээний илрүүлэлт 100%, таарч 90.8%, онч 92.5% байна. Цаг уур, орчны шинжилгээний газарт БНХАУ-аас Автомат хэмжигч багаж тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн.	70
6.4.2	Байгаль орчны салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ		Арга хэмжээ	Жилд нэг удаа	10	40	Ойн ангиуд харъяа ойн мэргэжлийн 54 байгууллагатай Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 ААНБ, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин 100.0 сая төгрөгөөр усалгааны систем бүхий иж бүрэн хүлэмж өгсөн. Ensure төсөлтэй хамтран 10 арга хэмжээ, АДАПТ төсөлтэй хамтран 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн.	70
6.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								70
ЗУРГААДУГААР БҮЛГИЙН ДҮН								62.50
ДОЛОО. АМАР ТАЙВАН АМЬДРАЛ								
7.1	БАТЛАН ХАМГААЛАХ							

7.1.1	Өсвөр үе, залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоно	Хамрагдсан хүний тоо	Жилд нэг удаа	1,500	2,000	Аймгийн Засаг даргын 2022 оны А/311 дүгээр захирамжаар Монгол цэрэг Нэгдсэн үндэсний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн баярыг тохиолдуулан аймагт үйл ажиллагаагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудыг хамруулсан "Монгол цэрэг энхийн үйлсэд" нээлттэй хаалганы өдөр, сурталчилгааны арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 29-ны өдөр аймгийн төв талбайд зохион байгуулж, 250 гаруй хүүхэд, залуучууд хамрагдсан. Тосонцэнгэл сумын Соёлын төвөөс аймгийн хойд чиглэлийн 11 сумыг хамруулан зохион байгуулсан Завхан аймгийн Тосонцэнгэл сумын уугуул Бригадын генерал Ч.Цогтжаргалын нэрэмжит "Цэргийн дууг хэн сайн дуулах вэ" дууны уралдааны зохион байгуулалтад хамтран ажиллав. Тус уралдаанд Бригадын генерал Ч.Цогтжаргал оролцож шилдгээр шалгарсан уран бүтээлчдэд шагнал гардуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас 1 тусгай байрын шагналыг ивээн тэтгэсэн. Зэвсэгт хүчний 101 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Цэрэг эх орны сэдэвт яруу найраг, уран уншлагын уралдааныг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан. Уралдаанд Улиастай сумын ЕБС-ийн 50 гаруй сурагчид оролцсон. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн төв хэвлэл болох "Соёмбо", "Эх орны манаа" сониныг 24 суманд захиалан өгч иргэдийг салбарын мэдээ, мэдээллээр хангах нөхцөл бүрдсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/314 дүгээр захирамжаар цэрэг-спортын Дөл тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоо 450 гаруй сурагчид хамрагдаж, шалгарсан тасгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит цэрэг спортын Улсын аварга шалгаруулах "Дөл" цогцолбор тэмцээнд оролцуулав. Улсын аварга шалгаруулах "Дөл" цогцолбор тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 30 багаас 8 дугаар байрт шалгарлаа. Тус тэмцээнд оролцсон шилдэг сурагчдыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Зэвсэгт хүчний 311, 326 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцах аялалыг зохион байгуулав. Мөн Монгол орны түүхэн дурсгалт газар "Цонжин болдог", Монгол Улсын анхны нийслэл "Хархорум", байгалийн үзэсгэлэнт газар "Тайхар чулуу", "Чулуутын гол", "Хоргын тогоо", "Тэрхийн цагаан нуур"-т аялуулсан.	50
7.1.2	Орон нутгийн хамгаалалтын бэлэн байдлыг бэхжүүлнэ	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	20%	100%	Аймгийн "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу орон нутгийн хамгаалалтын 4 бүсийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүнийг сум бүрээр оногдуулан дансалж, жил бүр тодотгол хийж байна. 2022 онд томилгоот бүрэлдэхүүний тодотголыг 24 суманд хийсэн. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/524 дүгээр захирамжаар жил бүр цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын 5 хувийг орон нутгийн хамгаалалтын нөөцөд хуримтлуулан ажиллаж байна. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 28-30-ны хооронд аймгийн Орон нутгийн хамгаалалтын 4 бүсийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгууллаа.	50
7.1.3	Дайчилгааны төлөвлөлтийг зохион байгуулна	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	50%	80%	2022 оны 05 сард сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт "Сумын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах" сэдвээр сургалт зохион байгуулж, дайчилгааны төлөвлөгөө боловсруулах талаар заавар, зөвлөмж, чиглэл өгсөн. Аймгийн Засаг даргаар тогтоосон хугацаанд дайчилгааны төлөвлөгөөг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. "Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө"-ний дагуу Цэргийн штабын даргын 2022 оны 14 дүгээр албан бичгийн дагуу Орон нутгийн цэргийн отряд, сумангийн орон тоо, албан тушаалын дагуу оногдуулан данслагдсан бүрэлдэхүүнд тодотгол хийх ажлыг Улиастай сумын 6 баг, Тэлмэн, Идэр, Яруу, Сонгино, Алдархаан сумдад хийсэн. Дайчилгааны бэлэн байдлыг хангах чиглэлд Үндэсний Батлан хамгаалах их сургууль, Зэвсэгт хүчний 325 дугаар ангитай хамтранбэлтгэл офицерын сургалтад 1, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн 7, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 30 хүний бүрэлдэхүүнтэй сургалтыг хууль заасан хугацаанд зохион байгуулан явуулав. Холбогдох тайлан мэдээг ЗХЖШ, БХЯ-нд хүргүүлсэн. Дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Зэвсэгт хүчний 274 дүгээр тусгай салбарт оногдуулан данслагдсан бүрэлдэхүүнд 2022 оны 11 дүгээр сард тодотгол хийсэн.	50
7.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							50
7.2.	НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ						
7.2.1	Гэмт хэргийн гаралтыг бууруулан, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ	Гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/	Сар бүр	67.1%	70.0%	Нийт гэмт хэргийн 317 буюу 78.3 хувийг хөнгөн, 88 буюу 21.7 хувийг хүнд гэмт хэрэг эзлэж байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хөнгөн хэрэг 9 хэргээр буюу 2.9 хувиар, хүнд гэмт хэрэг 29 хэргээр буюу 49.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 271 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 170 гэмт хэргийн сэжигтэнийг олж тогтоон, яллагдагчаар татсанаар гэмт хэргийн илрүүлэлт 62.7 хувьтай тооцогдсон нь өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурсан, илрээгүй гэмт хэрэг 101 буюу нийт гэмт хэргийн 24.9 хувийг эзлэж байна.	50
7.2.2	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана	Зам тээврийн гэмт хэрэг буурсан үзүүлэлт /нэгж/	Жилд хоёр удаа	25	12	ХАБТХАЖЭ гэмт хэрэг 27 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 80.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	30

7.2.3	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.		Эрх зүйн сургалт, сурталчилгаа хүргэсэн иргэдийн тоо	Жилд хоёр удаа	9000	10000	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан e-khutuch.mn сайтыг сумдын эрх зүйн хөтөч нараар дамжуулан иргэдэд сурталчлан таниулан ажиллаж байна. Баруун бүсийн худалдааны төвийн 1 давхарт эрх зүйн хөтчийн буланг байрлуулан ажиллалаа. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран аймгийн хэмжээнд 53 эрх зүйн хөтчийг бэлтгэсэн бөгөөд уг хөтөч нартай 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажиллалаа. Нийт мэдээлэл хүргэсэн хүний тоо 9800 байна. /Давхардсан тоогоор/	90
7.2.4	Орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлнэ		Бэлтгэл сургалтанд хамрагдсан иргэд, ААН-ийн хувь	Жилд нэг удаа	18%	50%	Аймгийн Засаг даргын 2022 оны А/308 дугаар захирамжаар баталсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Асгат, Цэцэн-Уул суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, сургалтад нийт 155 хүн 13 машин техник хамрагдсан. 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Баянтэс, Тэс, Нөмрөг сумдад ажиллалаа. Нөмрөг, Тэс сумдын гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд ерөнхий боловсролын сургуулийн 1142 сурагч, 91 багш, ажилчид, цэцэрлэгийн 142 хүүхэд, 28 багш, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын нийт 205 ажилчин, алба хаагч, 1373 иргэн нийт 2981 хүн оролцсон.	100
7.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								67.5
7.3	ХУУЛЬ САХИУЛАХ							
7.3.1	Орон нутаг дахь хууль сахиулах байгууллагуудын чадавхыг бэхжүүлнэ		Хөрөнгө оруулалтаар	Жилд нэг удаа	-	2.0	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үрэг бүхий байгууллагуудын чадавхыг бэхжүүлэн ОНТ-өөс 160 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хангах үүднээс удирдлагуудын уулзалтыг улиралд 1 удаа зохион байгуулж байна.	70
7.3.2	Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ		Терроризмын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ	Жилд нэг удаа	-	8.0	Терроризмын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 70 хувийн хэрэгжилттэй байна. Мөн ТЕГ-ын Завхан аймаг дахь хэлтсийн үйл ажиллагаанд 30 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тус байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. /нууц/	70
7.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								70
7.4	МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ							
7.4.1	Хөдөө орон нутаг, сум багийн суурин утас, интернетийн сүлжээг өргөжүүлнэ		Дахин дамжуулах станц	Жилд нэг удаа	12	18	Их-уул, Алдархаан, Эрдэнэхайрхан, Тэлмэн, Идэр, Отгон сумдын 8 багт Юнителийн 4G сүлжээний станцууд шинээр баригдаж ашиглалтад орсон. Яруу, Тосонцэнгэл, Баянтэс, Их-Уул сумдын 6 багт Юнителийн 4G сүлжээний хамрах хүрээний өргөтгөл хийгдсэн. Эрдэнэхайрхан, Идэр, Сонгино, Тосонцэнгэл, Улиастай сумдын 7 багт Мобикомын 4G сүлжээний дахин дамжуулах станц шинээр барьсан. Жи-Мобайлын 8ш дахин дамжуулах станц шинээр баригдаж, 13 станцад сүлжээний өргөтгөлийн ажил хийгдсэн.	50
7.4.2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлын сурталчлан ард иргэдэд түгээнэ		Мэдээний тоо	Жилд нэг удаа	120	150	Завхан аймагт болж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ард иргэдэд чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэхийг зорин ажиллаж байна. 2021 онд давхардсан тоогоор 300 гаруй, 2022 онд орон нутагт зохион байгуулж буй онцлох үйл явдлын 350 гаруй мэдээллийг бэлтгэж, Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз болон орон нутгийн телевизүүд цахим сайтуудаар нэвтрүүлж, сонин сэтгүүлүүдэд нийтлэн улс орон даяар сурталчилж ажилласан. "ДДИШ" ТВ-ийн сувгаар орон нутгийн мэдээ мэдээллийг 24 сум, бусад аймгуудад нэвтрүүлэхэд аймгийн Засаг даргын зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	70
7.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								60
ДОЛДУГААР БҮЛГИЙН ДҮН								61.875
НАЙМ. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ								
8.1	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ							
8.1.1	Аймгийн аялал жуулчлалын гол, туслах маршрутад түшиглэн үйлчилгээ, мэдээллийн төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ		Жуулчдын тоо	Жилд нэг удаа	23920	70000	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Тосонцэнгэл суманд зочид буудал, Эрдэнэхайрхан, Тэлмэн, Сонгино сумдад шинээр жуулчны баазууд байгуулагдсан.	50
8.1.2	"Улаагчны хар нуур", "Отгонтэнгэр хайрхан"-ыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ		Жуулчдын тоо	Жилд нэг удаа	15000	60000	Улаагчны хар нуурын бүсэд 100-150 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадал бүхий жуулчны бааз, ресторан шинээр байгуулагдаж эхэлсэн. Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газар болон Улаагчны хар нуурын байгалийн цогцолборт газарт 32040 жуулчин нэвтэрсэн байна.	50

8.1.3	Завхан аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх иж бүрэн маркетингийн арга хэмжээг хэрэгжүүлнэ		Жуулчдын тоо	Жилд нэг удаа	23920	70000	Аймгийн аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг 5 дугаар сард анх удаа зохион байгуулж салбарын 100 хүнийг оролцуулсан. Тэлмэн нуурын аялал жуулчлалын бүсийн зураг төсвийн ажлыг Сонголт дизаййн ХХК гүйцэтгэж байна. Одоогоор амралт, аялал жуулчлалын зориулалтаар Отгон, Тэлмэн сумдад 5 газарт 3.19 га талбайг олгоод байна. 55852 жуулчин манай аймгийг зорин ирсэн.	50
8.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								50.00
8.2.	ХӨДӨӨ АЖ АХУЙ							
8.2.1	Эрүүл өндөр ашиг шимт мал сүргийг үржүүлнэ		Өндөр ашиг шимт малын тоо	Жилд нэг удаа	177.4	200	Улиастай, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Алдархаан, Тосонцэнгэл, Шилүүстэй сумдад сүү-махны чиглэлийн 625 үхрийг 26 иргэн, аж ахуй нэгж үржүүлж байна. Улиастай, Цэцэн-уул, Тэс, Сонгино сумдад 11 иргэн 113 тооны гахай, Улиастай, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанчулуут сумдад 5 иргэн, аж ахуйн нэгжид 3800 гаруй тооны тахиа үржүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс эрлийз, хосолмол үхрийн тоо толгой 8%-иар буурч, гахайн тоо толгой 10%-иар өсч, тахиа тоо толгой 2%-иар өссөн байна. Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан сумдад Сартуул үүлдрийн хонь, Дөрвөлжин сумд Завхан буурал үүлдрийн ямаа, Тэс, Баянтэс сумд Тэс үүлдрийн адуу, Их-Уул, Тосонцэнгэл сумд Нутгийн сарлаг зэргийг үржүүлж байна. Мал сүргийн чанар, үүлдэр угсааг хадгалан, сайжруулж ажиллах тал дээр жил бүр Цөм сүргийн салбар нэгжтэй хамтран цөм сүргийн малд ангилалт хийдэг бөгөөд энэ жил "5 суурьд" сартуул үүлдрийн 1.665 хонинд ангилалт хийж үүнээс хээлтэгч 1.362, Хээлтүүлэгч-203, шинээр хурган хуц-100, Завхан буурал үүлдрийн 70 ямаанд ангилалт хийж, хээлтэгч-60, хээлтүүлэгч-10 ялган тэмдэглэх бүртгэлжүүлэх ажлыг хийж гүйцэтгэж, анги чанарын үзүүлэлтээр нь ялган ангилалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. "Шилмэл мал-2022" цахим үзэсгэлэн, дуудлага худалдаанд оролцох цэвэр үүлдрийн хээлтүүлэгч малд шилэн сонголт хийж Цөм сүргийн Завхан салбарын Завхан буурал үүлдрийн 2 ухна, Сартуул үүлдрийн 2 хуц шалгаран оролцсоноос Бүдүүвтэр ноосны номинацид тэргүүн байранд Сартуул үүлдрийн хуц, ноолуур амьдын жин номинацид дэд байранд Завхан буурал үүлдрийн ухна шалгарч шагнал хүртсэн. Яруу сумын Жаргалант мал хоршооны Завхан буурал үүлдрийн 2 ухныг үрийг нь авч генийн банкинд хадгалах зориулалтаар Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүлсэн. Цөм сүргийн төвд, дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллахаар Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ний А/522 дугаар захирамж гаргуулан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 5 сая төгрөгөөр Миний тулга ХХК гэрээ хийж нутгийн үхрийн махны гарцыг нэмэгдүүлэх, сайжруулах зорилгоор цэвэр герефорд үүлдрийн бухыг орон нутагтаа авчирч, тус захирамжаар томилогдсон ажлыг хэсэг хүлээн авсан.	70
8.2.2	Бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, малын тэжээл тариалалтыг дэмжинэ		Хураан авсан ургацын хэмжээ	Жилд хоёр удаа	3	23	2022 онд 3603 га-д малын тэжээл тариалж үүнээс 604 га тариалсан талбай ургац алдаж үр тарианы ургамлаас 510 га тэжээлд шилжин ирж 3509 га-гаас 4768.1 тн ногоон тэжээл хураан авсан. Асгат суманд үр тариалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгж 1650 га-д уриншийн боловсруулалт хийсэн. Өнгөрсөн онд аймгийн хэмжээнд 7541.2 га-д газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байсан бол энэ онд 8220.8 га-д хүрсэн нь өмнөх оноос 679.6 га-гаар тариалангийн талбай нэмэгдсэн байна.	50
8.2.3	Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно		Байгуулсан сүлжээний тоо	Жилд нэг удаа	0	2	Хоршоог хөгжүүлэх сангаас малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, зах зээлд худалдан борлуулах чиглэлээр төсөл ирүүлсэн Шилүүстэй сумын "Өсөх ундарга булаг" ХХК-нд 20.0 сая, Түдэвтэй сумын "Нүхэн хад салхит" ХХК-нд 15.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Мах боловсруулах, бэлтгэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Завхан хүнс групп" ХХК нь өнгөрсөн онд 20 мянган толгой малын дайвар бүтээгдэхүүнийг ялган савлаж хүн амын хүнсний хэрэгцээнд худалдан борлуулж 30.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.	50
8.2.4	Малчдын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ		Хамрагдсан малчдын тоо	Жилд нэг удаа	300	1500	2021 оны ноосны урамшуулалд хамрагдах 6824 өрхийн падааны шивэлтийг 24 сумаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Падааны шивэлтийг үйлдвэрийн шивэлттэй тулгахад анхан шатны мэдээлэл зөрүүтэй 1465, аймгийн мэдээлэл алдаатай 97, үйлдвэрийн мэдээлэл алдаатай 50 гаруй өрхийн мэдээллийг засварлан ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Төрөөс малчин болон мал бүхий иргэдэд олгодог ноосны урамшуулалд 2021 онд 6843 өрхийн урамшууллын гүйлгээ хийгдсэнээс нэр, данс зөрүүтэй 4000 гаруй иргэний мэдээллийг засварлан хүргүүлсэнээс дахин засварлах шаардлагатай 152 иргэний мэдээллийг засварлан хүргүүлээд байна. Энд онд Тосонцэнгэл сумын Рашаант, Оргих, Улаан толгой багуудад 4 малчин, Тэлмэн сумд 5 малчин, Их-Уул сумд 2 малчин, Нөмрөг сумд 5 малчин буюу нийт 17 малчин өвөлжөөндөө байшин барьсан байна. 2022-2023 оны өвөл, хаврын улиралд зэргэлдээх аймгуудад отор нүүдэл хийх малчдын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын албан тоотыг Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн удирдлагуудад хүргүүлсэн.	50

8.2.5	Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлнэ		Хэмжээ	Жилд нэг удаа	6,274.8	10,105.4	Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2022 онд Хоршоо хөгжүүлэх сангаас нийтийн хоол, худалдаа үйлчилгээ, сүү, цагаан идээ, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тахиа, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 3 сумын 5 аж ахуйн нэгж, 1 хоршоонд 125 сая төгрөгийн зээл олгосон. Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон баталгаажуулалтын зөвлөл сар бүр 2-3 удаа хуралдаж 2022 оны 5 сарын байдлаар нийт хүнсний худалдаа эрхлэгч 132 аж ахуйн нэгжид шинээр болон хугацаа сунгалт хийн тохирлын гэрчилгээ олгосон. 4 аж ахуйн нэгжийн 8 нэр төрлийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээг олгож үйл ажилгааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Сумдад үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүрүүдтэй хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэлт, хадгалалтын горим, тээвэрлэлтийн байдал зэргийг төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулах тал дээр хамтран ажиллаж хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүр мэдээг авч байна.	50
8.2.6	Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ		Байгуулагдсан хүлэмжийн тоо	Жилд хоёр удаа	11	65	2022 оны жилийн эцсийн байдлаар 2 аж ахуйн нэгж, 56 өрх 4092 м2 талбайд хүлэмжийн тариалалтаа хийж 20.9 тн ургац хураан аваад байна. Тэс, Улиастай сум шинээр нийт 152 м2 талбай бүхий 3 хүлэмжийг хувийн хөрөнгөөр, Тосонцэнгэл суманд төслийн 280.0 сар төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Тосон Эко хүнс" ногоочдын бүлэг шинээр 300 м2 өвлийн хүлэмж байгуулж тариалалт хийсэн байна.	70
8.2.7	Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ		Тариаланчдын тоо	Жилд нэг удаа	250	1500	Монгол улсын Засгийн газраас газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд аймгийн хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 78 аж ахуйн нэгж, 573 өрхийн судалгааг сумдаас авч нэгтгэн ХХААХУЯамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн. Хас банк Улиастай сумын 2 тариаланчдад 30.0 сая төгрөгийн, ХААН банк 19 иргэн, аж ахуйн нэгжид 470.2 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Өрхийн тариалан эрхэгчдийг дэмжих зорилгоор Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр олгосон 11 төрлийн 8.7 сая төгрөгийн 103.05 кг хүнсний ногооны үр, 17.5 сая төгрөгийн 1500 кг төл сонгинын үр, 2000 кг төмсний үрийг 23 суманд хуваарилан ХААТасгаар дамжуулан 27 аж ахуйн нэгж, 250 өрхийн тариалан эрхлэгчдэд олгосон.	70
8.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								58.57
8.3	ДЭД БҮТЭЦ							
8.3.1	Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ		Хатуу хучилттай замын урт	Жилд нэг удаа	560	1200	2022 онд Арц суурь-Нөмрөг чиглэлийн 167 км авто зам, Алтай-Улиастай чиглэлийн 198 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төсөл хийгдэж байна. Идэр, Түдэвтэй, Яруу, Сантмаргаз, Цэцэн-Уул сумдыг хатуу хучилттай төв авто замаар холбох ажлын саналыг ЗТЯ-нд хүргүүлсэн. 2022 онд Доной нисэх буудлаас Алдархаан сум хүртэлх 6.7км хатуу хучилттай авто замын ажил хийгдсэн. Их-Уул сумын төвийн дотор 3км хатуу хучилттай авто замын явган зам, хашлага, тэмдэг тэмдэглэгээ хийгдэж байна. Мөн 2022 онд Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67км хатуу хучилттай авто замын ажил ашиглалтад орж, Улиастай сумаас нийтийн тээврийн автобус гарах зогсоолыг шийдвэрлэж хийлгэсэн.	70
8.3.2	Улиастай болон зарим сумын инженерийн шугам сүлжээг шинэчилнэ		Хийгдсэн цэвэр усны шугамын уртаар хэмжинэ	Жилд нэг удаа	80	120	2022 онд Алдархаан, Отгон сумдын инженерийн шугам сүлжээ он дамнан хийгдэж байгаа бөгөөд Алдархаан сумын ажил дуусаж комисс хүлээгдэж байна. Отгон сумын дулааны шугам сүлжээ бүрэн хийгдэж дууссан. Хувийн аж ахуй нэгжийн санхүүжилтээр Их-Уул сумын төвлөрсөн халаалт, цэвэр усны шугам сүлжээ хийгдэж ашиглалтад орсон. 21-р зуун хороололд 2.4 км дулаан, хэрэглээний халуун ус, 1,2 км усан хангамж, 1,5 км ариутгах татуургын магистраль шугам сүлжээ хийгдэж ашиглалтад оруулсан. Дулааны станц, 11 дулаан дамжуулах төв, 1-р контор буюу төв шугам сүлжээний ажлыг БНСолонгос улсын тал 2 контор буюу дулаан дамжуулах төвөөс хэрэглэгчид хүрэх шугам сүлжээг Монгол улс хариуцан хийхээр гэрээнд тусгагдсан. Дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний ажил 9.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт тусуулах шаардлагатай. Улиастай суманд Богдын гол баг бор дүнзэн байрны хэсэгт 400 м ариутгах татуурын шугам, Товчоо багт бохир усны насос станц 2.2 км ариутгах татуургын шугамын ажил хийгдэж байна. Хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр Их-Уул сумын төвлөрсөн халаалт, цэвэр усны шугам сүлжээг хийж ашиглалтад оруулсан.	50
8.3.3	Төв, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна		Сумын тоо	Жилд нэг удаа	5	10	2021-2022 онд ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар Цэцэн-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийж, Улсын төсвийн санхүүжилтээр Алдархаан, Отгон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэсэн. Завхан аймгийн 24 сумаас төв суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэсэн 5 сум байна.	30

8.3.4	Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ	Эрэмбэ	Жилд нэг удаа		2022 онд Улсын төсвийн 600.0 сая төгрөгийн санхүүжилтээр Идэр сумын 12 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, Улиастай сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн өргөтгөл, спорт заалны барилга, Тэс, Цэцэн-Уул сумын 15 ортой ЭМТ-ийн барилга, Нутгийн удирдлагын ордоны барилга Улиастай, Дөрвөлжин, аймгийн цагдаагийн газрын спорт заал, Улиастай сумын 3-р цэцэрлэгийн өргөтгөл, Яруу сумын 160 хүүхдийн сургууль зэрэг 11 барилгын зураг төслийг Эрхэс констракшн ХХК хийж гүйцэтгэж байна. ОНТ-ийн 500.0 сая төгрөгийн санхүүжилтээр Отгон, Сонгино, Шилүүстэй соёлын төвийн барилга Улиастай сумын 3-р сургуулийн спорт заал, Яруу сумын эрүүл мэндийн төвийн барилга, Товцог багийн ариутгах татуургын шугамын төсвийн шинэчлэл хийлгэх Улиастай суманд шинээр баригдах дулааны станцын барилгын гадна ЦДАШ зэрэг 17 барилга байгууламжийн зураг төслийг хийлгэж байна. 2023 оны Улсын болон Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хийх ажлуудыг эрэмбэлж холбогдох газруудад хүргүүлсэн.	30
8.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН					36.67	
НАЙМДУГААР БҮЛГИЙН ДҮН					48.41	
НЭГДСЭН ДҮН					54.66	

120

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Товчилсон үгийн тайлбар

Урт болон дунд хугацааны хөтөлбөр бодлогын баримт бичгийн товчилсон үгийн тайлбар

МУТЖҮЧ-Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл
ЗГҮАХ-Засгийн газрынүйл ажиллагааны хөтөлбөр
АТЖҮЧ-Аймгийн таван жилийн Үндсэн чиглэл
АЗДҮАХ-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

Хөрөнгийн эх үүсвэрийн товчилсон үгийн тайлбар

УТ- Улсын төсөв
ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
ОНХС (СЗ) - Орон нутгийн хөгжлийн сан (Суурь зардал)
ОНТ - Орон нутгийн төсөв
ЖДҮХС- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
СХС- Сум хөгжүүлэх сан
ТХ - Төсөл хөтөлбөр
БХНСАХЗ - Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЦМТ-Цэргийн мөнгөн төлбөр
БӨХ-Байгууллагын өөрийн хөрөнгө
СЗДТГ-Сумын Засаг даргын Тамгын газар /сумын өөрийн хөрөнгө/

АЗДТГ - Аймгийн Засаг даргын тамгын газар
ТЗУХ - Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
ХОХБТХ - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
НБХ - Нийгмийн бодлогын хэлтэс
СТСХ-Санхүү төрийн сангийн хэлтэс
ХЭЗХ - Хууль, эрх зүйн хэлтэс
ХШУДАХ-Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ЦШ-Цэргийн штаб
БГ - Боловсролын газар
ЭМГ - Эрүүл мэндийн газар
ЦГ- Цагдаагийн газар
ХХААГ-Хүнс, хөдөө аж ахуйн газар
МЭГ-Мал эмнэлгийн газар
ОНӨГ-Орон нутгийн өмчийн газар
АОК- Аймгийн онцгой комисс
ОБГ-Онцгой байдлын газар
ГБХЗХГ-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

БОАЖГ-Байгаль орчин аялал жуулчлалын газар
АЖХ-Аялал жуулчлалын холбоо
ГХБХБГ-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МХГ-Мэргэжлийн хяналтын газар
ХАҮТ-Худалдаа аж үйлдвэрийн танхим
ИНБ-Иргэний нийгмийн байгууллага
ДЗОУБ-Дэлхийн зөн олон улсын байгууллага
НДЭХ-Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбоо
УЦУОШТ-Ус цаг уур орчны шинжилгээний төв
ТББ-Төрийн бус байгууллага
БМДИ-Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
ББОБТ-Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв
ХЖТ-Хөгжимт жүжгийн театр
ЗӨСТ-Зоонозын өвчин судлалын төв
АНЭ-Аймгийн Нэгдсэн эмнэлэг
ТНЭ-Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлэг
БТСГ-Биеийн тамир спортын газар
ХХҮГ-Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

Хэрэгжүүлэх байгууллага, хэлтэс, агентлагийн товчилсон үгийн тайлбар

СЗДТГ-Сумын Засаг даргын Тамгын газар
СГЗ-Сав газрын захиргаа
ААН-Аж ахуйн нэгж
ХТҮА-Хот тохижилт үйлчилгээний алба
ОМБ-Ойн мэргэжлийн байгууллага
СДОА-Сум дундын ойн анги
БХЯ-Батлан хамгаалах яам
СХ-Статистикийн хэлтэс
СХЗХ-Стандарт хэмжил зүйн хэлтэс
НҮБ-ХС-Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан
ГХУССЗ-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
УЗХ-Улаан загалмайн хороо
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль